



2010

ШАРЫН ГОЛ ХУВЬЦААТ
КОМПАНИ
ӨРИЙГ ХУВЬЦААНД
ХӨРВҮҮЛЭХ ТӨСӨЛ



ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ НЬ МОНГОЛ УЛСЫН “КОМПАНИЙН ТУХАЙ ХУУЛЬ”, “ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ” БОЛОН МОНГОЛ УЛСЫН САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ХОЛБОГДОХ ЖУРМУУДЫН ДАГУУ ӨӨРИЙН ДҮРМИЙН САНГ НЭМЭГДҮҮЛЖ, ӨРИЙГ ХУВЬЦААНД ХӨРВҮҮЛЖ БАЙГАА БОЛНО.

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 7.1-Д ЗААСНЫ ДАГУУ ХААЛТТАЙ ХҮРЭЭНД ӨРИЙГ ХУВЬЦААНД ХӨРВҮҮЛЭХЭЭР ГАРГАЖ БУЙ ЭНЭХҮҮ ҮНЭТ ЦААСЫГ САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО БҮРТГЭСЭН НЬ УГ ҮНЭТ ЦААСНЫ ЭРСДЛИЙН ТАЛААР АЛИВАА БАТАЛГАА ГАРГААГҮЙ БОЛОХЫГ АНХААРАХ НЬ ЗҮЙТЭЙ. ЭНЭХҮҮ ҮНЭТ ЦААСЫГ ХУДАЛДАН АВАХ ЗАМААР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ТАНЫ ХУВЬД **ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ** ҮЙЛДЭЛ БАЙДГИЙГ ОНЦГОЙЛОН АНХААРЧ, ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА, ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААГ САЙТАР АНХААРАН СУДАЛСНЫ ҮНДСЭН ДЭЭР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЙДВЭРЭЭ ГАРГАХЫГ ЗӨВЛӨЖ БАЙНА.

Энэхүү үнэт цаасны (хувьцааны) танилцуулгад хөрөнгө оруулагч танд хувьцаа худалдан авах шийдвэр гаргахад туслах, шаардлагатай бүхий л мэдээллийг агуулахыг зорьсон болно. Танилцуулгад хөрөнгө оруулагч танд шаардлагатай мэдээллийг бүрэн оруулаагүй байж болох ба лавлах тодруулах зүйлийг танилцуулгад заасан газраас болон Андеррайтерын “БиДиСек” ХК-д хандаж авна уу.



**Ерөнхий зуучлан борлуулагч:
Монголын Хөрөнгийн Биржийн гишүүн
“БиДиСЕК” Хувьцаат Компани
Андеррайтер, Брокер, Дилер,
Хөрөнгө Оруулалтын Зөвлөх
www.bdsec.mn**

**Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Залуучуудын өргөн чөлөө 27/1, “БиДиСЕК” ХК-ний байр**

НЭГ. КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ	5
1.1 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ КОМПАНИЙН ХАЯГ	5
1.2 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ КОМПАНИЙН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ	5
1.3 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ КОМПАНИЙН ТҮҮХ	5
1.4 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ КОМПАНИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, САЛБАР ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРЫН ТАНИЛЦУУЛГА	9
1.5 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ КОМПАНИЙН 5-С ДЭЭШ ХУВИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦУУЛГА	10
1.6 ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУДЫН МЭДЭЭЛЭЛ	11
1.7 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ КОМПАНИЙН БУСАДТАЙ БАЙГУУЛСАН ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЭЛ.....	12
1.8 КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ, НОГДОЛ АШГИЙН БОДЛОГЫН ТАЛААР	14
1.9 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ КОМПАНИ, ТОЛГОЙ БОЛОН ОХИН КОМПАНИ, КОМПАНИЙ ХЯНАЛТЫН БАГЦЫГ ЭЗЭМШИГЧИД, ТЭДГЭЭРИЙН НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭДИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ.....	16
1.10 КОМПАНИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ	16
1.11 СҮҮЛИЙН 4 ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	22
1.12 ҮНЭЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГААР ХИЙЛГЭСЭН БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ	25
ХОЁР. ӨРИЙГ ХУВЬЦААНД ХӨРВҮҮЛЭХ ТӨСӨЛ, НЭМЖ ГАРГАХ ҮНЭТ ЦААС	26
2.1 ҮНЭТ ЦААСНЫ ТӨРӨЛ	26
2.2 ҮНЭТ ЦААС ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ.....	26
2.3 УРЬД НЬ ГАРГАСАН ҮНЭТ ЦААСНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ	26
2.4 ҮНЭТ ЦААСЫГ БАЙРШУУЛАХ ХЭЛБЭР, ГРАФИК	28
2.5 ӨРИЙГ ХУВЬЦААНД ХӨРВҮҮЛЭХ ТӨСӨЛ	29
2.6 ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДАД УЧИРЧ БОЛОХ ЭРСДЛИЙН ШИНЖИЛГЭЭ	39
2.7 АНДЕРРАЙТЕР	44

Хүснэгтүүд

Хүснэгт 1 Гурван том уурхайн нүүрс олборлолтын хэмжээ.....	7
Хүснэгт 2 Үнэт цаас эзэмшигчдийн мэдээлэл.....	10
Хүснэгт 3 Эрх бүхий албан тушаалтнуудын мэдээлэл	11
Хүснэгт 4 ТУЗ-ийн гишүүдийн мэдээлэл	11
Хүснэгт 5 Их хэмжээний хэлцлийн жагсаалт	12
Хүснэгт 6 Баланс	24
Хүснэгт 7 Орлогын тайлан	25
Хүснэгт 8 Хөрөнгийн үнэлгээний нэгтгэл.....	26
Хүснэгт 9 Нүүрсний компаниудын хувьцаануудын ханшийн харьцуулалт.....	27
Хүснэгт 10 Хувьцааны арилжааны судалгаа	27
Хүснэгт 11 Зээлийн зарцуулалт	33
Хүснэгт 12 Triton Coal-ийн данснаас зарцуулсан мөнгөний зарцуулалт	33
Хүснэгт 13 Зарцуулалтын задаргаа	33
Хүснэгт 14 Хувьцааны тоо	37
Хүснэгт 15 Зээлдүүлэгчдийн хувьцааны бүртгэлд орох өөрчлөлт	37

Зурагнууд

Зураг 1 Компанийн байршил	6
Зураг 2 Бүтэц зохион байгуулалт.....	9
Зураг 3 Одоогийн олборлолт явуулж буй уурхайн хөрс хуулалтын зураг	17
Зураг 4 Үнэт цаасыг тараан байршуулах хэлбэр, график.....	28
Зураг 5 Шарын голын талбайн дэлгэмэл зураг.....	34
Зураг 6 Лицензийн талбайд өрөмдлөг хийсэн цооногийн тэмдгэлгээ	34

Графикууд

График 1 Гурван том уурхайн нүүрс олборлолтын хэмжээ.....	7
График 2 Хувьцаа эзэмшигчдийн бүтэц, тоо	10
График 3 Нүүрс олборлолт, борлуулалт	17
График 4 Хөрс хуулалт	18
График 5 Нүүрсний үнэ	18
График 6 Тоног төхөөрөмжийн наслалт	19
График 7 Арилжааны судлагаа	28
График 8 Хувьцааны зах зээлийн үнийн мэдээлэл.....	36

НЭГ. КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ

1.1 ҮНЭТ ЦААС ГАРАГЧ КОМПАНИЙН ХАЯГ

Дархан – Уул аймаг, Шарын гол сум, Санжит баг
Утас: 01 - 37 – 2235, 99111 952
E-mail: otgonzul@sharyngol.com

1.2 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ КОМПАНИЙН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Компанийн оноосон нэр: “ШАРЫН ГОЛ” ХК
Байгуулагдсан огноо: 1965 он
Улсын бүртгэлийн дугаар: 1910010009
Регистрийн дугаар: 2050374
Ашигт малтмал олзворлох тусгай зөвшөөрөл: 1498А лицензи
Уурхайн талбайн хэмжээ: 1827,9 гектар талбай
Үйл ажиллагааны үндсэн чиглэл: Чулуун нүүрс олзворлох

Үйл ажиллагаагаа хугацаагүйгээр явуулах. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг 2007 оны 3 дугаар сарын 16 өдөр 30 жилийн хугацаатайгаар аваад байна.

Холбогдох гэрчилгээний хуулбарууд хавсралт 1, 2-д

1.3 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ КОМПАНИЙН ТҮҮХ

Шарын голын нүүрсний ил уурхай нь Хэнтийн нурууны салбар Дархан уулын өвөрт далайн түвшинөөс дээш 920 м-ийн өндөрт Дархан-Уул аймгийн Шарын гол сумын нутагт орших бөгөөд Улаанбаатар хотоос 240 км, Дархан хотоос 50 км-ийн зайтай оршино. Нүүрсний уурхай нь ЗХУ (хуучин нэрээр)-ын техник эдийн засгийн тусламжтайгаар 1965 оны 4-р сарын 6-нд жилдээ 1.1 сая тонн нүүрс олдворлож , 5.0 сая шоо метр хөрс хуулах хүчин чадалтайгаар анх байгуулагдаж байсан. 1981 оноос хүчин чадлыг өргөтгөн жилдээ 10000 мян.шоо метр хөрс хуулж, 2000-2500 мян. тн нүүрс олборлохоор техник-технологои өөрчлөн, тоног төхөөрөмжүүдээ шинэчлэн суурилуулсан.

Хувьцаа эзэмшигчдийн 1995 оны 1-р сарын 21-ний өдрийн хуралдаанаар 723138.9 мянган төгрөгийн дүрмийн сантайгаар “Шарын гол” ХК болон зохион байгуулагдсан юм. Шарын голын уурхай нь Улаанбаатар Дархан хоттой төмөр зам, авто замаар холбогдсон. Дарханы эрчим хүчний системтэй 110 кв-ийн шугамаар холбогдсон.

Зураг 1 Компанийн байршил



Уурхайн нь карьер, үйлдвэрийн талбай инженерийн барилга байгууламж төмөр замын болон авто бульдозерийн овоолго, ус шүүрүүлэлтийн гүний уурхай зэрэг үндсэн хэсэг объектуудаас бүрдсэн 1827.5 га лицензийн талбайд байрласан.

Нүүрсний балансын нөөц нь 116680.2 мян.тн гэж тогтоогдсон. Балансын нөөцөнд 0,9м-ээс бага биш зузаантай дундаж үнслэгтэй, чулуулгийн үеүүдийн бохирдолт 48%-аас багатай нүүрсний давхагуудыг оруулж тооцсон. Балансын бус нөөцөд 0,9м-ээс бага зузаантай үнслэг нь 50% хүрсэн нүүрсний давхаргууд орно.

Шарын голын нүүрс нь хүрэн нүүрснээс чулуун нүүрсэнд шилжих үеийн нягт бат бэх барьцалдсан хар өнгийн агаарт сайн хадгалагддаг өөрөө шатамхай нүүрс бөгөөд Б-3 маркад хамаарна.

Нийт хөрөнгийн 80 хувь буюу 578511.1 мянган төгрөгийн хөрөнгийг төрийн өмчийн харъяалалд үлдээж 20 хувь буюу 144627.8 мянган төгрөгийн хөрөнгөнд ноогдох 1446278 ширхэг хувьцааг хөрөнгийн биржээр арилжаалуулсныг 3738 хувьцаа эзэмшигч худалдан авч тус компаний хувьцаа эзэмшигчид болцгоосон билээ. Ингэж тус уурхай нь хувьцаат компани болон өөрчлөн зохион байгуулагдсанаар удирдлага, зохион байгуулалтын хувьд ч эзэмшигчдийн бүтцийн хувьд ч өөрчлөгдсөн юм.

2003 оны сүүлчээр засгийн газрын шийдвэрээр төрийн өмчийн мэдлийн хувьцааг дахин хувьчилж бүрэн хувьчлагдсан хэлбэрээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулж байна.

Тус уурхай нь ил аргаар ашиглалт явуулдаг, манай улсын эрчим хүчний нүүрсний томоохон үйлдвэрүүдийн нэг бөгөөд Улаанбаатар, Эрдэнэт, Дархан, Сэлэнгэ зэрэг аймаг, хот, зарим сум, үйлдвэр аж ахуйн төвүүдэд түлш нийлүүлэх үндсэн үүргээ байгуулагдсанаас хойшхи бүх хугацааны туршид бүрэн биелүүлж ирсэн билээ.

Манай улсын эрчим хүчний нүүрс олборлодог эхний 3 том уурхайн сүүлийн 10 жилийн нүүрс олборлолтын хэмжээ /мянган тонн/

	2000	2001	2002	2003	2004
Багануур	3 066,0	3 140,5	3 049,3	3 045,7	2 711,0
Шивээ овоо	603,3	793,2	899,0	941,3	1 308,7
Шарын гол	709,0	676,8	693,6	664,9	678,8
	2005	2006	2007	2008	2009
Багануур	2 811,4	2 804,4	2 794,3	3 000,4	3 005,8
Шивээ овоо	1 200,3	1 306,7	1 415,0	1 450,6	1 400,0
Шарын гол	710,5	514,7	545,7	548,3	420,6

Хүснэгт 1 Гурван том уурхайн нүүрс олборлолтын хэмжээ




График 1 Гурван том уурхайн нүүрс олборлолтын хэмжээ

Тус уурхай нь төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооны үед ОХУ-д үйлдвэрлэгдсэн 2 СБШ-200Н 9 ЗСБШ-200-60, СБР-160 маркийн өрмийн машин, 4-10 шоо метрийн багтаамж бүхий шанагатай ЭКГ-4у, ЭКГ-5 А, ЭКГ -8 И , ЭШ-6/45, ЭШ-10/70 маркийн гинжит болон алхагч экскаваторууд , 1000-1100 морины хүчтэй ТЭМ-1, ТЭМ-2 маркийн илчит тэрэг , 60-105.0 тоннын даацтай 7BC-60, 2BC -105 маркийн вагон самосвалууд, 27-40 тоннын даазтай Белаз-540, Белаз-548 маркийн автосамосвалууд , ДЭТ-250 , Т-170 маркийн бульдозер зэрэг уулын хүчирхэг техник тоног төхөөрөмжүүдийг үе шаттайгаар нэвтрүүлж үйлдвэрлэлийнхээ үйл ажиллагааг явуулж ирсэн юм.


Харин улс орон зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэн ба уул уурхайн шинэ дэвшилтэт техникүүд бий болж гадаад харилцаа өргөжсөнөөр 1992 оноос эхлэн Япон улсад үйлдвэрлэсэн “Коматцу” маркийн бульдозер, Англи -Хятадын хамтарсан үйлдвэрийн “ Терекс” маркийн өөрөө буулгагч өндөр даацын автомашин, АНУ-ын каторфилер пүүсийн 6 шоо метр шанаганы багтаамжтай авто ачигч, 769 D маркийн 40 тоннын даацтай КАТ автосамосвал , дугуйт бульдозер , авто грейдер зэрэг орчин үеийн өндөр чадамжтай техникүүд ашиглах болсон юм.

- Тус уурхай нь 1988 оноос Бурхантын шороон ордыг, 1993 оны 8-р сараас Хүйтний шороон ордыг өөрийнхөө харъяалалд авч ажиллуулснаар нүүрс олзворлохын зэрэгцээ алт олзворлох нэмэлт үйлдвэрлэл эрхлэн ашиг орлогоо нэмэгдүүлэх боломжийг бий болгосон юм.
- 1999 онд Дулааны станцын үнс зайлуулах системийг өөрчилж үнсийг усаар зайлуулах ажлыг эхлэв. Коматцу бульдозеруудын хөдөлгүүрийг шинэчлэн тавив. Өрөмдлөгийн ажлын хоцрогдлыг арилгах зорилгоор Баганнуур ХК-аас 3 СБШ-250 MN-60 өрөм авч ажиллуулав. 1999 онд 2873.2 мян.м3 хөрс хуулж 771.8 мян.тн нүүрс гаргаж, 768.3 мян.тн нүүрс борлуулав. Нүүрсний үйлдвэрийн хөдөлмөрийн бүтээмж уулын цулаар 1999 онд 1998 оныхоос 1193 м3-ээр буурсан байна. Алтны үйлдвэрийн хөдөлмөрийн бүтээмж 2348.3 м.төг-өөр өссөн байна. 1999 оны 12-р сард Хятад улсаас авчирсан 4 ш Терекс маркийн машиныг ашиглалтанд оруулав.
- 2000 онд 2625.4 мян.м3 хөрс хуулж 709 мян.тн нүүрс олборлов. Алтны хэсгүүд 122.77 кг алт олборлож 102.5 кг алт борлуулав.
- 2001 онд Хятад -Английн хамтарсан үйлдвэрийн Терекс 3305 маркийн 5 ш терексийг ашиглалтанд оруулав.
- 2002 онд тус компаний 2008 он хүртэлх үйл ажиллагааны төслийг боловсруулж засгийн газарт өргөн барьж, засгийн газрын 180-р тогтоолоор авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийн шийдвэрийг гаргав. 2002 онд бурхантын алтны уурхай нөөцөө дууссан тул татан буугдав. 2002 онд компани 2355.6 мян.м3 хөрс хуулж 698.2 мян.тн нүүрс гаргаж, 704.5 мян.тн нүүрс борлуулав. 24.7 кг алт олборлож 20.85 кг алт борлуулав. 2002 онд Бурхантын алтны үйлдвэрийг, 2007 онд Хүйтний алтны үйлдвэрийг татан буулгав.
- 2003 оны 7-р сард засгийн газрын 180 дугаар тогтоолын шийдвэрээр Дулааны станц, УСДШС-г орон нутгийн өмчийн газар болгон тусгаарлав. 2003 оны 11 сард хувьчлагдаж Би энд Жи группийн мэдэлд шилжив. 2003 онд 2680.6 мян.м3 хөрс хуулан, 664.9 мян.тн нүүрс олзворлон , 663.1 мян.тн нүүрс борлуулав.
- Хувьчлагдсан анхны жил 2004 онд 675.8 мян.тн нүүрс олзворлон 3466.3 мян.м3 хөрс хуулав. Автаар 2703 мян.м3 хөрс тээвэрлэсэн нь 40 жилийн түүхэндээ автын хөрс тээвэрлэлтийн хамгийн дээд амжилт юм. 2004 онд бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийн, ажиллагсдын сахилга дэг журмыг сайжруулан бүтээлийг нэмэгдүүлснээр энэ амжилтанд хүрсэн болно.
- 2005 онд 2274.3 мян.м3 хөрс хуулж, 710.5 мян.тн нүүрс олзворлов. Монгол улсын 2005 оны “ТОП-100” аж ахуйн нэгж, Аймгийн “ТОП” ААН, оны шилдэг аж ахуйн нэгж. Сумын тэргүүний аж ахуйн нэгжээр шалгарав.

- 2006 онд 2665.0 мян.м3 хөрс хуулж, 514.7 мян.тн нүүрс олзворлосноос 130.3 мян.тн-ыг балансын бус нөөцөөс олзворлосон байна.
- 2007, 2008, 2009 онуудад Монгол улсын “ТОП-100” –д шалгарав. 2007 онд 545.7 мян.тн нүүрс олзворлон, нүүрс тээвэрлэх 760 м конвейерыг барьж ашиглалтанд оруулахад бэлэн болгов. Мөн оны эцсээр Коматцу Д-155 маркийн /106/ бульдозер шинээр ашиглалтанд оруулав.
- 2008 онд ил аргаар карьерын ТӨВ болон Хойд хэсгийн хананаас 411.3 м.тн, улнаас 129.5 м.тн, зүсэлтийн шугам VIII-XI хооронд гүний комбайн ашиглан далд аргаар 7.5 м.тн, нийт 548.3 м.тн нүүрс олзворлож, 2384.9 м.м3 хөрс хуулсан байна. 2008 онд тоног төхөөрөмжийн эвдрэл саатал, хүрэлцээгүй байдлаас шалтгаалан 2009-2010 онд олзворлох нүүрсний нөөц нээх хөрс хуулалтын ажил хугацаа хоцорч байсан боловч өвлийн ид ачааллын үеэр нүүрс олзворлолтын төлөвлөгөөг ханган биелүүлж 2009.01.01-нд 100.0 мян.тн нүүрсний нөөцтэй шилжин, нийт хөрс хуулалтын төлөвлөгөөг биелүүлсэн нь 2008 оны ажлын гол үр дүн юм.

1.4 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ КОМПАНИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, САЛБАР ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРЫН ТАНИЛЦУУЛГА

Компанийн бүтэц зохион байгуулалтыг дараах схемээр харуулав.



Зураг 2 Бүтэц зохион байгуулалт

1.5 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ КОМПАНИЙН 5-С ДЭЭШ ХУВИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦУУЛГА

№	Үнэт цаас эзэмшигч	Эрхэлдэг ажил, байршил	Эзэмшиж буй хувь
1	FB Global master fund	АНУ, Хөрөнгө оруулалтын сан	33.2
2	FB Global master fund-2	АНУ, Хөрөнгө оруулалтын сан	13.1
3	FB Mongolia fund	АНУ, Хөрөнгө оруулалтын сан	8.1
4	“Шарын гол Энерго” ХХК	Монгол улс, ААН	13.6
5	Д.Доржпүрэв		22.1
6	Бусад	Жижиг хувьцаа эзэмшигчид	9.9
Нийт			100

Хүснэгт 2 Үнэт цаас эзэмшигчдийн мэдээлэл

Хувьцаа эзэмшигчдийн бүтэц хувиар

Хувьцаа эзэмшигчдийн тоо




График 2 Хувьцаа эзэмшигчдийн бүтэц, тоо

2010/07/31-ны өдрөөр хувьцаа эзэмшигчдийн тархалтын судалгаа
хавсралт 3-д

1.6 ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУДЫН МЭДЭЭЛЭЛ

	Овог нэр	Мэргэжил	Албан тушаал	Хувьцаа эзэмшдэг эсэх
1	С.Насанбат	Эдийн засагч, эрх зүйч	Гүйцэтгэх захирал	Үгүй
2	Т.Шофёр	Уул, уурхайн ашиглалтын инженер	Дэд захирал	Үгүй
3	Ж.Эрдэнэбат	Уулын инженер маркшейдер	Ерөнхий технологич	Үгүй
4	Л.Даваасүрэн	Эдийн засагч	Ерөнхий санхүүч	Үгүй

Хүснэгт 3 Эрх бүхий албан тушаалтнуудын мэдээлэл

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН МЭДЭЭЛЭЛ

	Овог нэр	Мэргэжил	Албан тушаал	Хувьцаа эзэмшдэг эсэх
1	Б.Батмөнх	Санхүүч	"Шарын гол"ХК-ийн ТУЗ-ийн дарга	Үгүй
2	Anthony Milewski	Хуульч	"Firebird management" LLC	Үгүй
3	Ж.Батболд	Уул уурхайн инженер	"Шарын гол энерго"ХХК-ийн захирал	235`997 3.2%
4	Д.Байлхүү	Эдийн засагч	Төрийн өмчийн хорооны зөвлөх	45`952 0.64%
5	Ц.Ганбат	Холбооны инженер	"Шарын гол трейдинг" ХХК-ийн гүйцэтгэх захирал	Үгүй
6	Д.Даянбилгүүн	Бизнесийн удирдлага	"БиДиСек"ХК-ийн гүйцэтгэх захирал	Үгүй
7	Joseph Naemi	Хувиараа бизнес эрхлэгч	Австрали: Ninox Capital Pty Ltd, Valant Petroleum Pty Ltd, Triton Hydrocarbons Pty Ltd, Сингапур: Triton coal Pte Ltd	Үгүй
8	James Passin	Эдийн засагч	Firebird Global Fund-ийн захирал	Үгүй
9	Ian Jason Spence	Геологич	Австрали: Valant Petroleum Pty Ltd, Сингапур: Triton coal Pte Ltd	Үгүй

Хүснэгт 4 ТУЗ-ийн гишүүдийн мэдээлэл

1.7 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ КОМПАНИЙН БУСАДТАЙ БАЙГУУЛСАН ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЭЛ

Компанийн тухай хуулийн 84-р зүйлд заасны дагуу хэлцэл хийхийн өмнөх балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл.

Компанийн бусадтай байгуулсан их хэмжээний хэлцэл

№	Активын дүнд эзлэх хувь	Гэрээний агуулга	Гэрээ байгуулсан огноо	Гэрээ баталсан эрх бүхий байгууллагын тогтоол, шийдвэр
1.	34,3%	Хувьцаанд хөрвөх санхүүжилтын гэрээ	2010/04/30	2010/04/30-ны хувь нийлүүлэгчдийн хурал
2.	32,35%	JORC өрмийн хөтөлбөр	2010/04/30	2010/04/30-ны хувь нийлүүлэгчдийн хурал

Хүснэгт 5 Их хэмжээний хэлцлийн жагсаалт

1. ХУВЬЦААНД ХӨРВӨХ САНХҮҮЖИЛТЫН ГЭРЭЭ

“Шарын гол” ХК /цаашид Зээлдэгч гэх/ нь өөрийн орд газрын нөөцийг шинэчлэн тогтоох, нөөцийн тайланг олон улсын стандартад нийцсэн JORC стандартаар бэлдүүлэх, өрмийн ажлын санхүүжилтэнд зориулан 2010/04/30-ний өдөр Firebird Mongolia Fund, Firebird Global Master Fund, Firebird Global Master Fund II /цаашид Зээлдүүлэгч гэх/ компаниудтай нийт 4,5 сая долларын үнийн дүн бүхий хөрвөх санхүүжилтын гэрээг байгуулсан. Гэрээний хугацаа 6 сар, хүүгийн хэмжээ жилийн 15%.

Гэрээ нь 20 зүйл бүхий, Зээлдэгч тал санхүүжилтыг Triton Coal ХХК-тай байгуулсан гэрээ, үйлчилгээний төлбөрт зарцуулах, гэрээний хугацаа дуусгавар болоход Зээлдүүлэгчийн хүсэлтийн дагуу Зээлдэгч нь зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг бэлнээр болон компанийн хувьцаанд хөрвүүлэн төлж барагдуулахаар заагдсан.

Гэрээг батлагдсан: 2010 оны 04-р сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар Firebird компани болон “Шарын гол”ХК-ийн хооронд байгуулагдах Хөрвөх санхүүжилтын гэрээг баталснаар гэрээ хүчин төгөлдөр болсон.

Гэрээ нь сонирхолын зөрчилтэй эсэх: Тус гэрээ нь компанийн нийт хувьцааны хяналтын багц эзэмшигч, нэгдмэл сонирхолтой этгээдүүд болох Firebird группын 3 сантай байгуулагдсан тул компанийн тухай хуулийн 86-р зүйлийн дагуу сонирхолын зөрчилтэй хэлцэлд тооцогдоно. Гэрээ нь 2010/04/30-ны өдрийн хувь

нийлүүлэгчдийн хурлаар, тус асуудлаар саналын эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн саналаар батлагдсан.

Гэрээ хүчинтэй эсэх: 2010 оны 07-р сарын 20-ны өдөр хуралдсан ТУЗ-ийн хурлаар гэрээг дуусгавар болгон зээлийг хувьцаанд хөрвүүлэх асуудлыг хэлэлцэж зөвшөөрсөн. Хөрвөх хувьцааны үнийг зээлийн гэрээг дуусгавар болгосон 2010.07.20-ны өдрөөс өмнөх 52 долоо хоногийн дунджаар буюу 4221 төгрөгөөр тогтоосон.

Гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилт: Зээлдүүлэгчид нь гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийг ханган 2010/04/30-2010/07/20 нд 3`870`000 долларыг дансанд шилжүүлсэн.

2010 оны 08-р сарын 31-ний Хувьцаа эзэмшигчдийн хурлаар өрийг хувьцаанд хөрвүүлэх асуудлыг хэлэлцэн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар нийт 5`456`047`716 төгрөгийн зээлийг нэгж хувьцааны үнийг 4221 төгрөгөөр тооцоолон 1`292`596 ширхэг хувьцаанд хөрвүүлэхээр баталсан.

Зээл авах тухай ХНХ-ийн тогтоол хавсралт 6-д

Гэрээний эх хувь болон орчуулга хавсралт 7-д

2. JORC ӨРМИЙН ХӨТӨЛБӨР

Компани нь олон улсын стандартад нийцсэн, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалсан, нээлттэй засаглалтай компани болох зорилгоор олон ажил гүйцэтгэж байгаагийн нэг нь өөрийн орд газрын нөөцийг шинэчлэн тогтоох, нөөцийн тайланг олон улсын стандартад нийцсэн JORC стандартаар бэлдүүлэх, тайланг бэлдэхэд шаардагдаж буй мэдээллүүдийг гаргаж авахаар өрмийн ажлыг гүйцэтгүүлж байна. Тус ажилд дараах компаниуд гүйцэтгэгчээр оролцож байна.

1. Triton Coal – Төслийн удирдагч
2. Ellecor Driling – Өрмийн ажил гүйцэтгэгч
3. Micromine – Зөвлөх, нөөцийн тайлан бэлтгэгч
4. Stewarts Lab – Нүүрсний чанарын үзүүлэлт шалгагч лаборатори

Triton Coal

“Шарын гол” ХК нь уурхайн төслийн менежментийн ажлыг гүйцэтгүүлэхээр Triton Coal ХХК /цаашид төслийн удирдагч гэх/ -тай 2010/04/30-ны өдөр гэрээ байгуулан ажиллаж байна.

Төслийн удирдагч нь:

- Төслийн санхүү тооцоог барих,
- Төсөлтэй холбогдох ажил гүйцэтгүүлэх талуудыг сонгох, гэрээ байгуулах, ажилд хяналт тавих,
- Төслийн талаарх мэдээллээр компанийг бүрэн хангах үндсэн үүрэгтэйгээр
- Хяналтыг тавьж, хөрөнгийг хариуцах хэдий ч хөрөнгийн эзэмшил, төслийн удирдлагын эрхгүй ажиллаж байна.

Хамтран ажиллах гэрээ, орчуулга хавсралт 36-д

Ellecor Driling

Энэхүү гэрээг 2010/04/30-ны өдөр “Ellecor” ХХК-ийг төлөөлж гүйцэтгэх захирал Christopher Aanensen, “Шарын гол” ХК-ийг төлөөлж ТУЗ-ийн дарга Б.Батмөнх нар гарын үсэг зурж баталсан. Гэрээний үндсэн зохицуулалт нь Ellecor ХХК нь үйлчлүүлэгчийн санал болгосон хэмжээсийн дагуу PQ3 болон HQ3 зэрэг стандартаар 13,000 /арван гурван мянган/ метр өрөмлөг хийж гүйцэтгэх. Цооног тус бүрийн гүн нь талбайн геологчийн зааврын дагуу гүйцэтгэгдэх ба 400 хүртэл метр байхаар заагдсан, 6 зүйл бүхий гэрээ.

Хамтран ажиллах гэрээ, орчуулга хавсралт 37-д

Stewarts Lab

Тус гэрээг 2010/04/30-ны өдөр “Stewarts Lab” ХХК-ийг төлөөлж ерөнхий захирал О.Ширнэн, “Шарын гол” ХК-ийг төлөөлж ТУЗ-ийн дарга Б.Батмөнх нар гарын үсэг зурж баталсан. Гэрээний үндсэн зохицуулалт нь Stewarts Lab нь нүүрсний дээжид шинжилгээг хийж гүйцэтгэн, дээжийн бүрэн мэдээллийг гарган өгөхөөр заагдсан 10 зүйл бүхий гэрээ.

Хамтран ажиллах гэрээ, орчуулга хавсралт 39-д

Micromine

Энэхүү гэрээг 2010/04/30-ны өдөр байгуулсан. Гэрээний үндсэн нөхцөл нь “Шарын гол” ХК нь нөөцийг шинэчлэн Австрали-Азийн нөөцийн ангиллалын ЖОРК стандартаар тогтоохдоо Майкромайн Уул Уурхайн Зөвлөхийн Үйлчилгээг /MCS/ авах, MCS нь өрөмдлөгийн зургийн загвар, өрөмдлөгийн гэрээний төсөл, түүний дэлгэрэнгүй тайлбар болон ЖОРК зэрэглэлийн бүхий л мөрдлөгийг хийн гүйцэтгэхээр заагдсан 8 зүйл бүхий гэрээ.

Хамтран ажиллах гэрээ, орчуулга хавсралт 38-д

1.8 КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ, НОГДОЛ АШГИЙН БОДЛОГЫН ТАЛААР

Компанийн дүрмийн 6 дугаар зүйлд зааснаар энгийн хувьцаа эзэмшигчид нь дараах эрхтэй байна.

Компанийн энгийн хувьцаа худалдан авч эзэмшсэн этгээд компанийн хувь нийлүүлэгч болно.

Компанийг татан буулгах үед компанийн тухай хуулийн 28 дугаар зүйлд тогтоосон журмын дагуу үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх эрхтэй.

Компаниас нэмж гаргасан хувьцаа, хувьцаанд хөрвөх үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэй.

Хувь нийлүүлэгчдийн хурлаас доорхи асуудлаар шийдвэр гаргахад эсрэг саналтай байсан, эсхүл санал хураалтад оролцоогүй хувь нийлүүлэгч бүр өөрийн эзэмшиж буй хувьцааг компани эргүүлэн авахыг шаардах эрхтэй.

- Нийлэх, нэгдэх, хуваах болон хязгаарлагдмал хариуцлагатай компани болгож өөрчлөх.
- Хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25%-иас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдаж авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл хийсэн, компани урьд гаргасан энгийн хувьцааны 25%-иас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа худалдаж авах эрхийн бичиг болон энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргасан зэрэг их хэмжээний хэлцэл хийсэн.
- Компанийн хувь нийлүүлэгчдийн эрхийг хязгаарласан нэмэлт өөрчлөлтийг компанийн дүрэмд оруулсан, эсхүл ийм агуулгатай компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг баталсан.

Нэг хувь нийлүүлэгч түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн хамт компанийн энгийн хувьцааны 75-аас дээш хувийг эзэмшиж байгаа тохиолдолд энгийн хувьцаа эзэмшигчид компанид хувьцаагаа эргүүлэн авахыг шаардах эрхтэй.

Энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувь нийлүүлэгч нь ээлжит хурал хуралдахаас ажлын 45 ба түүнээс дээш хоногийн өмнө хурлаар хэлэлцэх асуудлын талаар нэмэлт санал гаргах, компанийн ТУЗ гишүүн, эсхүл гүйцэтгэх удирдлагад нэр дэвшүүлэх эрхтэй.

Хувьцаа эзэмшигч нь “Компанийн тухай” хуулийн 66 дугаар зүйлийн 4-д заасан мэдээлэлтэй танилцах эрхтэй.

Компанийн энгийн хувьцааны нэг болон түүнээс дээш хувийг эзэмшигч нь компанийн эрх бүхий албан тушаалтны буруугаар компани болон өөрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.

Энгийн хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшигч нь компанийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаанд аудитийн шалгалт хийлгэх эрхтэй.

Хувь нийлүүлэгч нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү эзэмшиж байгаа хувьцааны хэмжээгээр хариуцлага хүлээнэ.

Ногдол ашиг хуваарилах нөхцөл

Ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх.

Ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, татан буулгалтын үнэ, хуульд заасан өөрийн хөрөнгийн доод хэмжээ зэргийн нийлбэрээс илүү байх.

Ногдол ашиг хуваарилаагүй бол ТУЗ үүний шалтгааныг хувь нийлүүлэгчдийн хуралд тайлагнана.

Ногдол ашиг хуваариласны дараа үлдэх ашгаас нийгэм соёлын арга хэмжээ, үйлдвэр хөгжүүлэх сан байгуулж болно. Сан байгуулах асуудлыг ТУЗ шийдвэрлэнэ. Уг санг байгуулах, түүний хөрөнгийг зарцуулах журмын төслийг гүйцэтгэх захирал боловсруулж ТУЗ-ийн хурлаар баталж мөрдөнө.

ТУЗ-өөс ногдол ашиг олгохоор зарласан боловч хууль журамд заасан хугацаандаа олгохгүй бол алданги төлөхийг шаардах эрхтэй.

Компанийн дүрэм хавтаст материалын хуудсанд

1.9 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ КОМПАНИ, ТОЛГОЙ БОЛОН ОХИН КОМПАНИ, КОМПАНИЙ ХЯНАЛТЫН БАГЦЫГ ЭЗЭМШИГЧИД, ТЭДГЭЭРИЙН НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭДИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

Компанийн олон нийтэд гаргасан нийт хувьцааны хяналтын багцыг дангаар болон нэгдмэл сонирхолтой этгээдийн хамт эзэмшдэг этгээд нь “Master fund” (FIREBIRD MANAGEMENT LLC) сан. Уг сан нь гадаадын хуулийн этгээд болно.

Албан ёсны хаяг: 152 west 57th street. New York, NY 10019

TEL : 212 698 9260

FAX : 212 698 9266

1.10 КОМПАНИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

1.10.1 Нүүрсний нөөцийн тухай

Шарын голын нүүрсний ордын нөөц тогтоосон геологи хайгуулын ажлын тайлан дээр үнэслэн 1963 онд ЗХУ-ын Ленинград хотын “ГИПРОШАХТ” институтэд боловсруулсан уурхайн ашиглалтын ТЭЗҮ-д ордын нийт балансын нөөцийг 116,7 сая тонноор тооцсон бөгөөд үүнээс 1963-2010 онуудад олборлосон 54,5 сая тонн, 1978 оны Улсын нөөцийн комиссын тогтоолоор баталсан балансын бус 39,0 сая тонн нүүрсний нөөцийг хасаж тооцсоноор 2011.01.01-ийн байдлаар уурхайн балансын нөөцийн үлдэгдэл 23,2 сая тонн үлдэж байгаа болно.

Анх тус уурхайн 1963 онд батлагдсан ТЭЗҮ-ийн үндэслэлд тусгагдсан нөөцийн тооцоо болон 1965-2010 оныг дуустал балансын нөөцийн олборлолтын дүн мэдээг хавсралт 41-д

Уулын ажлын болон байгаль орчин хамгаалах төлөвлөгөө хавсралт 40, 43-д

Орос, Монголын геологичид “Шарын гол”-ын нөөцийг тогтоож, ангилахдаа тухайн үеийн техник, технологийн боломж, нөхцөлд тохируулан баталсан байдаг бөгөөд боломжит нөөцийг харьцангуй доогуур тогтоосон гэж мэргэжилтнүүд үздэг.

Уг нөөцийг олон улсын стандартад нийцэх өнөөгийн дэвшилтэт технологиор батлах, нөөцийг нэмэгдүүлэх ажлыг компаниас 2010 оноос зохон байгуулж ажиллаж байгаа ба үр дүн нь ч сайн байхаар урьдчилсан үр дүнгээс харагдаж байна.

1.10.2 Компанийн өнөөгийн үйл ажиллагааны талаар

Шарын голын нүүрсний орд нь 1965 оноос 1498А тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн дагуу жилд 450-1000 мян тонн нүүрс олзворлон Дархан Уул, Орхон аймгуудын дулааны цахилгаан станцууд болон аж ахуйн нэгжүүдийг 3600-4000 ккал илчлэгтэй нүүрсээр тасралтгүй ханган ажиллаж байна.

Сүүлийн 10 жилийн нүүрс гаргалтын хэмжээ





График 3 Нүүрс олборлолт, борлуулалт

Сүүлийн жилүүдэд компанийн нүүрс олборлолтын хэмжээ буурсан нь дараах үндсэн шалтгаануудтай байна:

1. Хөрс хуулалт

Өмнөх онуудад хөрс хуулалтын ажлыг хангалттай хийж, гүйцэтгэж байгаагүйгээс хөрс хуулалтын нөхцөл хүндэрч, нэгж бүтээгдэхүүнд ноогдох хөрс хуулалтын хэмжээ ихэссэн нь нүүрсний өртгийг нэмэгдүүлж байгаа.



Зураг 3 Одоогийн олборлолт явуулж буй уурхайн хөрс хуулалтын зураг

Сүүлийн 10 жилийн хөрс хуулалтын хэмжээ



График 4 Хөрс хуулалт

2. Нүүрсний үнэ

Төрөөс цахилгаан эрчим хүч болоод нүүрсний үнийг шууд хянаж, өөрийн өртгөөс нь доогуур барьж байснаас нүүрсний олборлолт нэмэгдэх тусам компанийн хүлээх алдагдал ихэсч байснаас олборлолтын хэмжээг доогуур түвшинд барьж байсан.

Харин сүүлийн жилүүдэд нүүрсний үнийг нэмэгдүүлснээр 2010 оны 3-р улирлын байдлаар компани ашигтай ажиллаж эхлээд байгаа. Мөн Улсын Их Хурлаас нүүрсний үнийг аажим нэмэгдүүлэх замаар 2013 он гэхэд зах зээлийн үнийн түвшинд хүргэх шийдвэр гаргаад байна.

Сүүлийн 10 жилийн нүүрсний үнэ




График 5 Нүүрсний үнэ

3. Эргэлтийн хөрөнгийн хомсдол

Хөрс хуулалтын хэмжээ ихэссэн болон бусад бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс шалтгаалан нүүрсний өөрийн өртөг нэмэгдсэн, нүүрсний борлуулах үнийг төрөөс удаан хугацаанд нэг түвшинд барьсантай холбогдуулан компанийн санхүүгийн байдал хүндэрч, эргэлтийн хөрөнгийн хомсдолд орох болсон.

Компанийн сүүлийн 4 жилийн санхүүгийн үзүүлэлт хуудсанд

Энэ нь техник тоног төхөөрөмжийг шинэчлэх, ажиллагсдын цалин хөлсийг нэмэгдүүлэхэд сөрөг нөлөө үзүүлж, олборлолтын хэмжээг багасгахад нөлөөлсөн.

4. Техникийн насжилт

Дээр дурдсан шалтгаануудын улмаас техникийн насжилт өндөрсөж, шаардагдах сэлбэг хэрэгслийн хэмжээ ихэссэнээс гадна гол нь хүчин чадал нь их хэмжээний олборлолт хийхэд хүндрэл үүсгэсэн байна.

Уурхайн үндсэн техник тоног төхөөрөмжийн насжилт




График 6 Тоног төхөөрөмжийн насжилт

1.10.3 Уурхайн ирээдүйн төлөвлөгөө

2010 онд хийж гүйцэтгэсэн ажил

Уурхайд үүсээд байгаа дээрх нөхцөл байдлуудыг шийдвэрлэн компанийг дэлхийн стандартад нийцсэн уул уурхайн компани болгох үүднээс дараах ажлуудыг хийж гүйцэтгэхээр төлөвлөж байгаа бөгөөд 2010 оноос үе шаттайгаар хэрэгжүүлж эхлээд байна. Харьцангуй богино хугацаанд компанийн цаашдын үйл ажиллагааг жигд үр ашигтай явуулах чиглэлээр 2010 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

1. JORC нөөцийн програм

Уурхайн нүүрсний нөөцийг баталгаажуулан, олон улсын стандартад хүлээн зөвшөөрөгдөхүйц түвшинд шинэчлэн батлаар JORC нөөцийн программыг 2010 оны 5-р сараас хэрэгжүүлж эхлээд байна.

Олон улсын уул уурхайн зөвлөх болох Австрали, Бээжинд төвтөй Micromine компани JORC өрөмдлөгийн програмыг удирдан явуулах, Шарын голын уурхайн JORC-р баталгаажсан нөөцийг тодорхойлох зорилгоор томилогдон ажиллаж байна.

Программын хүрээнд нийт 17,699.90 метр өрөмдлөгийн ажил хийж гүйцэтгээд байна.

Үндсэн уурхайн баруун өмнө болон зүүн талуудад өрөмдлөгийн ажил явагдаж байгаа ба JORC өрөмдлөгийн тайлан нь уурхайд шинэчлэл болон өргөтгөл хийх үндэс суурь нь болох юм.

2. Ernst & Young олон улсын аудит

Компанийн санхүүгийн сахилга батыг дээшлүүлэх, зардлыг бууруулах арга замыг тодорхойлох, санхүүгийн байдалд зөв үнэлэлт дүгнэлт хийх боломжтой болох зорилгоор олон улсад нэр хүнд бүхий Ernst & Young аудитын компанитай гэрээ байгуулан ажиллаж байна.

3. Олон улсын зөвлөхүүд

Уул уурхайн болон санхүүгийн үйл ажиллагааг үр ашигтай, мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэн ажиллах зорилгоор туршлага бүхий гадаадын мэргэжилтэн зөвлөхүүдийг хөлслөн авч ажиллуулж байгаагийн дотор Санхүү эрхэлсэн захирлаар Англи улсын иргэн David Dring ажиллаж байна.

4. Компанийн засаглал

МХБ-д бүртгэлтэй хувьцаат компанийн хувьд компанийн засаглал, ил тод байдлыг дээшлүүлэх үүднээс авч гүйцэтгэсэн арга хэмжээнүүд:

- Хууль зүйн Due Diligence хийлгэсэн
- Шинэчилсэн бизнес төлөвлөгөө боловсруулсан
- Удирдлагын болон ажилтнуудын дахин сургалтыг кохион байгуулж байгаа
- Монголын компанийн засаглалын кодекст тохируулан 5 журам шинээр баталсан
- Компанийн цахим хуудас шинээр нээсэн

ОЙРЫН ХУГАЦААНД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. JORC программыг дуусгах

Шинээр хийгдсэн өрөмдлөгийн ажлын үндсэн дээр JORC стандартын иж бүрэн тайланг хүлээн авах, уурхайн цаашдын өргөтгөл, шинэчлэлийн ажлын үндсэн загварыг гаргах

2. Чанарын баталгаа

Уурхай дээр хэрэгжиж буй JORC өрөмдлөгийн програмын хүрээнд нүүрсний чанарыг тодорхойлохын тулд лабораторийн туршилт болон нүүрсний чанар шалгах ажлуудыг тогтмол хийж байх

3. Үйлдвэрлэлт

Зах зээлийн хэмжээг нэмэхийн тулд бүтээгдэхүүний гарцыг ихэсгэхийн тулд дараах боломжуудыг ашиглах:

Дотоодын зах зээл

- Дотоодын эрчим хүч үйлдвэрлэлтэнд харьцангуй бага чанартай нүүрс хэрэглэгдэж байгаа ба дотоодын цахилгаан станцуудад борлуулж буй нүүрс нь компанийн нийт борлуулалтын 75%-г эзэлж байна.
- УИХ, Засгийн газраас 2013 он хүртэл нүүрсний үнийг аажмаар нэмэгдүүлэх замаар цахилгаан станцуудад нийлүүлэгдэж байгаа нүүрсний үнийг зах зээлийн түвшинд хүргэх шийдвэр гаргаад байна.
- Дархан Сэлэнгийн бүс нутагт төмөрлөгийн болон хүнд металлургийн үйлдвэрлэл хөгжих ихээхэн ирээдүй байдаг бөгөөд сүүлийн жилүүдэд энэ чиглэлээр олон төсөл хөтөлбөр хэрэгжиж эхлээд байна.
- Утаагүй түлш болон цементийн зах зээл эрчимтэй хөгжих хандлагатай байгаа нь ирээдүйд нүүрс үйлдвэрлэлт нэмэгдэх боломжыг бүрдүүлж байна.

Экспортын зах зээл

- Нүүрсний чанар нэмэгдсэнээр ОХУ, БНХАУ, Япон, Солонгос зэрэг улсуудад нүүрс экспортлох боломжтой болох ба энэ нь борлуулалтын орлогыг нэмэгдүүлэхэд чухал үүрэгтэй.
- Стратегийн түншлэлүүд нь нүүрсний экспортыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой.
- Мөн олон улсын зах зээл дээр нүүрс борлуулах шинэ сувгуудыг (coal swaps) судалж үзэх нь борлуулалтыг дээд зэргээр нэмэгдүүлэх бидний зорилгын салшгүй хэсэг юм.

4. Бүтээгдэхүүний өртөг

Бүтээгдэхүүний өртгийг багасгах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Үүнд:

Техникийн шинэчлэл: Өндөр насжилттай техникийг шинэчилж, өндөр хүчин чадал бүхий шинэ техникийг ашигласнаар сэлбэг хэрэгслийн зардал буурч, хөдөлмөрийн бүтээмж эрс нэмэгдэх боломжтой юм.

Хөрс хуулалт: Одоогийн үүсээд буй хөрс хуулалтын ажлын нөхцөл байдал болон нүүрсний үеүүдийн онцлогоос хамааран уул уурхайн оновчтой технологийг боловсруулахаар туршлага бүхий уул уурхайн зөвлөх компанитай хамтран ажиллах

Шинэ ам нээх: JORC өрөмдлөгийн программын урьдчилсан прогнозоор одоогийн ашиглаж буй уурхайн амаас гадна шинэ ам нээх боломж бодитой харагдаж байгаа бөгөөд энэ тохиолдолд бүтээгдэхүүний өртөг эрс багасах бололцоотой.

5. Эргэлтийн хөрөнгө

2010 онд компанид хэрэгжсэн төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх зорилгоор авсан богино хугацаат зээлийг хувьцаанд хөрвүүлэх, техник, технологио шинэчлэх зорилгоор компаниас нийт 3 сая ширхэг хувьцаа гаргахаар шийдвэрлээд байна.

1.11 СҮҮЛИЙН 4 ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Баланс

/төгрөгөөр/

БАЛАНСЫН ЗҮЙЛ	2007	2008	2009	2010 III улирал
ХӨРӨНГӨ				
Эргэлтийн хөрөнгө				
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	104,815,501	623,257,193	284,578,670	1,434,373,598
Дансны авлага	7,317,469,654	4,820,334,140	4,299,667,500	3,908,934,757
Найдваргүй авлагын хасагдуулга	(385,881)	(385,881)	(385,881)	(385,881)
Бусад авлага	6,198,718	6,238,302	4,975,997	5,082,790
Бусад авлага /гадаад/				2,174,674,272
НӨАТ-ын авлага				100,807,026
Бараа материал	1,866,615,859	1,844,639,639	1,800,380,572	2,107,082,309
Мал амьтад	17,537,000	15,430,550	11,922,050	10,912,990
Урьдчилж төлсөн зардал /тооцоо	2,964,426	2,964,426	175,745,426	5,160,736,492
Эргэлтийн хөрөнгийн дүн	9,315,215,277	7,312,478,368	6,576,884,334	14,902,218,353
Эргэлтийн бус хөрөнгө				
Үндсэн хөрөнгө	12,013,430,015	11,638,182,862	11,996,161,739	10,614,054,452
Хуримтлагдсан элэгдэл	(8,746,220,717)	(8,374,752,838)	(9,071,859,346)	(7,755,867,789)
Биет бус хөрөнгө		38,312,696	38,312,696	38,312,696
Хуримтлагдсан элэгдэл		(4,469,815)	(12,770,899)	(18,517,803)

Хөрөнгө оруулалт ба бусад	8,400,000	181,181,000	8,400,000	8,400,000
Эргэлтийн хөрөнгийн бус хөрөнгийн дүн	3,275,609,298	3,478,453,906	2,958,244,190	2,886,381,556
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	12,590,824,575	10,790,932,273	9,535,128,525	17,788,599,909
Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч				
ӨР ТӨЛБӨР				
Богино хугацаат өр төлбөр				
Дансны өглөг	2,986,855,346	3,182,187,661	2,710,918,320	2,100,635,761
Цалингийн өглөг	58,079,312	70,007,382	56,685,351	77,919,411
ОАТатварын өглөг	32,137,400	20,153,491	26,580,545	164,632,885
ХАОАТ-ын өглөг	36,549,872	152,566,512		94,592,721
НӨАТ-ын өглөг	783,879,152	907,634,363	167,739,072	-
Бусад татварын өглөг	12,445,563	498,000	661,461	49,525,619
ЭМНД-ийн шимтгэлийн өглөг	299,459,381	275,617,524	223,827,285	98,684,430
Ногдол ашгийн өглөг		49,487,335		
Банкны богино хугацаат зээл	620,000,000			
Бусад өглөг	1,680,580,936	2,406,958,936	2,405,019,350	2,405,019,350
Зээлийн өглөг /гадаад/				7,472,749,410
Зээлийн хүүгийн өглөг /гадаад/				94,473,554
Урьдчилж орсон орлого	2,698,245	2,543,738	500,000	500,000
Богино хугацаат өр төлбөрийн дүн	6,512,685,208	7,067,654,941	5,591,931,384	12,558,733,140
Урт хугацаат өр төлбөр				
Урт хугацаат зээл	2,440,000,000			2,508,340,043
Бусад урт хугацаат өглөг	2,508,340,043	2,508,340,043	2,508,340,043	
Урт хугацаат өр төлбөрийн дүн	4,948,340,043	2,508,340,043	2,508,340,043	2,508,340,043
Өр төлбөрийн нийт дүн	11,461,025,251	9,575,994,984	8,100,271,427	15,067,073,183
Эзэмшигчдийн өмч				
Өмч: хувийн	723,138,900	723,138,900	723,138,900	723,138,900
Хувьцаат капиталын дүн	723,138,900	723,138,900	723,138,900	723,138,900
Дахин үнэлгээний нөөц	3,051,333,889	3,051,333,889	3,051,333,889	3,051,333,889
Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	1,700,139,876	1,700,139,876	1,700,139,876	1,700,139,876
Хуримтлагдсан ашиг /алдагдал	(4,344,813,341)	(4,259,675,376)	(4,039,755,568)	(2,753,085,939)
Тайлангийн үеийн	173,815,684	61,149,700	219,919,808	1,286,669,629

Өмнөх үеийн	(4,518,629,025)	(4,320,825,076)	(4,259,675,376)	(4,039,755,568)
Эзэмшигчдийн өмчийн дүн	1,129,799,324	1,214,937,289	1,434,857,097	2,721,526,726
Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн	12,590,824,575	10,790,932,273	9,535,128,525	17,788,599,909

Хүснэгт 6 **Баланс**

Орлогын тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2007 он	2008 он	2009 он	2010 III улирал
Үндсэн үйл ажиллагааны орлого				
Борлуулалтын орлого	8,371,437,273	10,626,651,032	9,550,701,731	7,165,621,399
Борлуулалтын хорогдол ба буцаалт	172,605,855	100,518,230	738,446,700	213,370,684
Борлуулалтын орлогын дүн	8,198,831,418	10,526,132,802	8,812,255,031	6,952,250,715
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	7,431,709,514	9,485,094,647	7,847,694,705	4,886,721,465
Нийт ашиг /алдагдал/	767,121,904	1,041,038,155	964,560,326	2,065,529,250
Үйл ажиллагаа /борлуулалт, ерөнхий удирдлага/-ын зардал				
Үндсэн болон нэмэгдэл цалин	125,203,438	165,413,482	209,132,335	151,263,257
Нийгмийн даатгалын шимтгэл	25,550,554	21,625,785	28,170,907	19,616,489
Засвар үйлчилгээний зардал	290,593	85,000		40,242,700
Ашиглалтын зардал	3,153,979	5,340,189	8,083,331	7,490,112
Түрээсийн зардал			900,000	500,000
Албан томилолтын зардал	7,054,380	5,873,600	19,087,676	8,380,294
Тээврийн зардал			49,980,900	30,395,178
Түүхий эд материалын зардал	3,634,422	4,827,953	1,833,965	10,136,684
Элэгдлийн зардал	25,614,667	33,655,402	71,419,464	32,516,470
Зар сурталчилгааны зардал	1,465,621	1,004,497	1,666,767	1,922,700
Шуудан, холбооны зардал	12,178,148	12,410,705	11,924,415	10,456,908
Шатахууны зардал	30,495,764	39,652,733	19,431,083	18,882,941
Бусад зардал	109,829,798	176,615,336	32,802,931	25,622,831
Үйл ажиллагааны зардлын дүн	344,471,363	466,504,681	454,433,775	357,426,563
Үндсэн үйл ажиллагааны ашиг /алдагдал/	422,650,541	574,533,474	510,126,551	1,708,102,687
Үндсэн бус үйл ажиллагааны ашиг /алдагдал/				
Үндсэн бус үйлдвэрлэл, үйлчилгээний ашиг /алдагдал	(133,358,258)	(150,234,291)	(123,235,719)	(221,244,893)
Торгууль, хөнгөлөлтийн ашиг /алдагдал/	(11,109,442)	(55,109,212)	110,552,937	

Валютин ханшийн өөрчлөлтөөс үүссэн ашиг хэрэгжсэн/алдагдал/	(5,423,119)	82,757,948	12,589,491	(92,369,510)
Валютин ханшийн өөрчлөлтөөс үүссэн ашиг хэрэгжээгүй /алдагдал/				(60,733,259)
Бусад	(66,806,638)	(370,645,149)	(263,532,908)	127,208,801
Үндсэн бус үйл ажиллагааны ашиг /алдагдал/-ын дүн	(216,697,457)	(493,230,703)	(263,626,198)	(247,138,860)
Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/	205,953,084	81,302,770	246,500,353	1,460,963,827
Орлогын татварын зардал	32,137,400	20,153,070	26,580,545	174,294,198
Татварын дараах ашиг /алдагдал/	173,815,684	61,149,700	219,919,808	1,286,669,629
Цөөнхөд ноогдох хувь				178

Хүснэгт 7 Орлогын тайлан

*Сүүлийн 4 жилийн санхүүгийн тайлан хавсралт 31-35-д
Аудитын тайланг хүлээн зөвшөөрч, зөвлөмжийг хэрэгжүүлэх тухай ТУЗ-ийн
тогтоол хавсралт 30-д*

**1.12 ҮНЭЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГААР ХИЙЛГЭСЭН БИЗНЕСИЙН
ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ**

Компанийн бизнесийн үнэлгээг 1911008137 улсын бүртгэлийн дугаар, №071200029, №081100099 тоот хөрөнгийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрлийн гэрчилгээ бүхий үнэлгээчидтэй “Капитал зууч” ХХК-аар гүйцэтгүүлсэн.

“Шарын гол” ХК нь нэмэлт хувьцаа гаргах болсонтой холбоотойгоор “Капитал зууч” ХХК нь тус компанийн 100 хувийн өмчийн бизнесийн үнэлгээ буюу нэгж хувьцааны зах зээлийн өнөөгийн үнэлгээг Олон улсын үнэлгээний стандарт, арга хандлага, аргачлалын дагуу бие даасан хараат бус байдалд хийж гүйцэтгэсэн.

Бизнесийн үнэлгээг цэвэр хөрөнгөд суурилсан хандлагаар үнэлэхэд тухайн компанийн үл хөдлөх ба хөдлөх хөрөнгийг өнөөгийн зах зээлийн үнээр илэрхийлэх шаардлагатай ба тус хөрөнгийн үнэлгээний тайланг “Капитал зууч” ХХК нь мөн хийж гүйцэтгэсэн. Бизнесийн үнэлгээний тайланг

- Орлого капиталжуулалтын хандлагаар
- Цэвэр хөрөнгөд суурилсан хандлага
- Зах зээлийн харьцуулалтын хандлагаар үнэлсэн байна.

Үнэлгээний компани нь бизнесийн үнэлгээний зорилго, зориулалтаас хамаарч үнэлгээний арга сонголт, үр дүн, давуу болон дутагдалтай талуудыг шинжилж

үзээд ирээдүйн цэвэр мөнгөн гүйлгээг хорогдуулан тооцох аргаар хийсэн бизнесийн үнэлгээнд 20 хувийн ач холбогдол өгч, өртгийн хандлагын аргаар хийсэн үнэлгээнд 60 хувийн ач холбогдол, зах зээлийн харьцуулалтын хандлагын салбарын коэффициентийн аргаар хийсэн үнэлгээнд 20 хувийн ач холбогдол өгч үнэлсэн байна.

Үнэлгээний арга	Тухайлсан үнэ цэнэ /сая.төг/	Ач холбогдол	Тооцсон дүн /сая.төг/
Орлого капиталжуулалтын арга	28 137,70	20%	5 627,5
Цэвэр хөрөнгөд суурилсан арга	16 519,73	60%	9 991,7
Зах зээлийн жишиг үнийн арга	30 718,90	20%	6 143,8
Компанийн бизнесийн үнэлгээ			21 683,0

Хүснэгт 8 Хөрөнгийн үнэлгээний нэгтгэл

“Шарын гол” ХК-ийн үнэлгээний өдрөөрх бизнесийн үнэ цэнэ нь 21 683,0 сая төгрөгөөр тодорхойлогдсон. Үнэлгээний байгууллагаар хийлгэсэн

Бизнес үнэлгээний дэлгэрэнгүйг хавсралт 44-45-д

ХОЁР. ӨРИЙГ ХУВЬЦААНД ХӨРВҮҮЛЭХ ТӨСӨЛ, НЭМЖ ГАРГАХ ҮНЭТ ЦААС

2.1 ҮНЭТ ЦААСНЫ ТӨРӨЛ

Хувьцааны төрөл: Энгийн

Нэрлэсэн үнэ: 100₮

Зах зээлийн үнэ (сүүлийн 6 сарын жигнэсэн дундаж): 4672₮

2.2 ҮНЭТ ЦААС ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ

Компанийн энгийн хувьцаа эзэмшигч нь Монгол Улсын “Компанийн тухай” хууль, “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулиудад заасан болон компанийн дүрэмд заасан хувьцаа эзэмших эрхийг эдлэнэ.

2.3 УРЬД НЬ ГАРГАСАН ҮНЭТ ЦААСНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Засгийн газрын “Өмч хувьчлалын комисс”-н шийдвэрээр 1995 оны 1-р сарын 21-ний өдрийн хуралдаанаар 723 138.9 мянган төгрөгийн дүрмийн сантайгаар “Шарын гол” ХК болон зохион байгуулагдсан.

Нийт хөрөнгийн 80 хувь буюу 578 511.1 мянган төгрөгийн хөрөнгийг төрийн өмчийн харъяалалд үлдээж 20 хувь буюу 144 627.8 мянган төгрөгийн хөрөнгөнд ноогдох 1 446 278 ширхэг хувьцааг хөрөнгийн биржээр дамжуулан арилжаалж,

нийт 3 738 иргэн хувьцаа эзэмшигч болон худалдан авч компанийн хувьцаа эзэмшигчид болсон.

2003 оны сүүлчээр засгийн газрын шийдвэрээр төрийн өмчийн мэдлийн хувьцааг бүрэн хувьчилж өнөөдрийн байдлаар гадаад дотоодын томоохон хөрөнгө оруулагчид хувьцааг нь эзэмшсэн хувийн өмчийн хэлбэрээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулж байна.

2011/01/06-ны байдлаар компанийн хувьцааны үнэ нэрлэсэн үнээс 105 дахин өсөөд байна. Бусад ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг хувьцаат компаниудын хувьцааны ханштай харьцуулсан харьцуулалт:

№	Хувьцааны нэр	Хувьцааны нэрлэсэн үнэ	Хувьцааны ханш /2011.01.06/	Өсөлт
1	Багануур	100	11,000	110 дахин
2	Шивээ овоо	100	12,500	125 дахин
3	Таван толгой	100	591,000	5910 дахин
4	Адуунчулуун	100	10,000	100 дахин
5	Могойн гол	100	11,800	118 дахин
6	Шарын гол	100	10,500	105 дахин

Хүснэгт 9 Нүүрсний компаниудын хувьцаануудын ханшийн харьцуулалт

СҮҮЛИЙН 2 ЖИЛИЙН ХУВЬЦААНЫ АРИЛЖААНЫ СУДАЛГАА

Ширхэг	1,344,546
Нийт гаргасан хувьцаанд эзлэх хувь	18,59
Үнийн дүн	12,521,349,310
Дээд үнэ	14,000
Доод үнэ	1,400
Хаалтын ханш /2011/01/06/	10,500

Хүснэгт 10 Хувьцааны арилжааны судалгаа




График 7 Арилжааны судлагаа

Монголын хөрөнгийн биржээс гаргуулсан сүүлийн 2 жилийн хувьцааны арилжааны судалгаа хавсралт 4-д

2011/01/06-ны байдлаар Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй нүүрсний уурхайнуудын хувьцааны зах зээлийн ханшийн нэрлэсэн үнэтэй нь харьцуулахад 100-5910 дахин өсөлттэй байна. “Шарын гол” ХК-ийн хувьцааны ханш нэрлэсэн үнээс 110 дахин өсөлттэй.

Сүүлийн 2 жилийн хугацаанд нийт 12,5 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 1 344 546 ширхэг хувьцаа арилжаалагдаж өдрийн дундаж арилжааны хэмжээ нь 24,8 сая төгрөг байгаа нь тус компанийн хувьцаа зах зээлд идэвхитэй арилжаалагддаг, хөрвөх чавдар бүхий хувьцаа гэж дүгнэж болохоор байна.

2.4 ҮНЭТ ЦААСЫГ БАЙРШУУЛАХ ХЭЛБЭР, ГРАФИК



Зураг 4 Үнэт цаасыг тараан байршуулах хэлбэр, график

2.5 ӨРИЙГ ХУВЬЦААНД ХӨРВҮҮЛЭХ ТӨСӨЛ

2.6.1 ТӨСЛИЙН ЗОРИЛГО

“Шарын гол” ХК-ийн 2010 оны 04 сарын 30-ний өдрийн хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлаар батлан Firebird Mongolia Fund, Ltd; Firebird Global Master Fund, Ltd; Firebird Global Master Fund II, Ltd-тэй /Цаашид Зээлдүүлэгчид гэнэ/ 2010 оны 04 сарын 30-ны өдөр байгуулсан зээлийн гэрээний дагуу үүссэн 3`870`000 /гурван сая найман зуун далан мянга/ буюу мөнгөн шилжүүлэг хийсэн өдрийн Монгол банкны ханшаар тооцох 5`337`957`180 /Таван тэрбум гурван зуун гучин долоон сая есөн зуун тавин долоон мянга нэг зуун ная/ төгрөгийн үндсэн өр болон 2010/07/20-ны өдрөөр тасалбар болгосон 118`091`941.98 /Нэг зуун арван найм ерэн нэгэн сая есөн зуун дөчин нэгэн төгрөг ерэн найман мөнгө/ төгрөгийн хүүгийн төлбөрийн нийлбэр нийт дүн болох 5`456`049`121.98 /Таван тэрбум дөрвөн зуун тавин зургаан сая дөчин есөн мянга нэг зуун хорин нэгэн төгрөг ерэн найман мөнгө/ төгрөгийг компанийн энгийн хувьцаанд хөрвүүлэн Зээлдүүлэгчдэд эзэмшүүлэх, хувьцааны үнэ болон ширхэгийг тогтоох, хэрэгжүүлэх нөхцлийг тодорхойлоход төслийн зорилго оршино.

2.6.2 ӨР ТӨЛБӨР ҮҮССЭН НӨХЦӨЛ

Өр үүссэн шалтгаан

Компани нь олон улсын стандартад нийцсэн, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалсан, нээлттэй засаглалтай компани болох зорилгоор 2009 оны 2 сараас 2010 оны 2-р сар хүртэл Triton Coal ХХК-иар бизнес төлөвлөгөө /Due diligence/ хийж гүйцэтгүүлсэн. Төлөвлөгөөний дагуу компани нь дараах ажлуудыг хийж гүйцэтгэж байна.

- 1 JORC нөөцийн програм
- 2 Ernst & Young олон улсын аудит
- 3 Олон улсын зөвлөхүүд
- 4 Компанийн засаглалыг сайжруулах

Хөрвөх санхүүжилтын гэрээ

Тус гэрээг нэг 2010/04/30-ны өдөр Firebird Mongolia Fund, Firebird Global Master Fund, Firebird Global Master Fund II компаниудыг төлөөлж менежер James Passin, “Шарын гол” ХК-ийг төлөөлж Төлөөлөн Удирдах зөвлөлийн дарга Б.Батмөнх нар гарын үсэг зурж баталсан.

Гэрээ нь 20 зүйл бүхий, Зээлдэгч тал санхүүжилтыг Triton Coal ХХК-тай байгуулсан гэрээ, үйлчилгээний төлбөрт зарцуулах, гэрээний хугацаа дуусгавар болоход Зээлдүүлэгчийн хүсэлтийн дагуу Зээлдэгч нь зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг бэлнээр болон компанийн хувьцаанд хөрвүүлэн төлж

барагдуулахаар заагдсан. Нийт 4,5 сая долларын үнийн дүн бүхий, жилийн 15%-ийн хүүтэй, 6 сарын хугацаатай хөрвөх санхүүжилтын гэрээ.

Гэрээг батлагдсан: 2010 оны 04-р сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар Firebird компани болон “Шарын гол”ХК-ийн хооронд байгуулагдах Хөрвөх санхүүжилтын гэрээг баталснаар гэрээ хүчин төгөлдөр болсон.

Гэрээ нь сонирхолын зөрчилтэй эсэх: Тус гэрээ нь компанийн нийт хувьцааны хяналтын багц эзэмшигч, нэгдмэл сонирхолтой этгээдүүд болох Firebird группын 3 сантай байгуулагдсан тул компанийн тухай хуулийн 86-р зүйлийн дагуу сонирхолын зөрчилтэй хэлцэлд тооцогдоно. Гэрээ нь 2010/04/30-ны өдрийн хувь нийлүүлэгчдийн хурлаар, тус асуудлаар саналын эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн саналаар батлагдсан.

Гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилт: Зээлдүүлэгчид нь гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийг ханган 2010/04/30-2010/06/27 нд 3`870`000 долларыг Зээлдэгчийн төслийн санхүүжилтэнд зориулан төслийн удирдагчийн дансанд шилжүүлсэн.

2010 оны 08-р сарын 31-ний Хувьцаа эзэмшигчдийн хурлаар өрийг хувьцаанд хөрвүүлэх асуудлыг хэлэлцэн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар нийт 5`456`047`716 төгрөгийн зээлийг нэгж хувьцааны үнийг 4221 төгрөгөөр тооцоолон 1`292`596 ширхэг хувьцаанд хөрвүүлэхээр баталсан.

Гэрээ хүчинтэй эсэх: 2010 оны 07-р сарын 20-ны өдөр хуралдсан ТУЗ-ийн хурлаар гэрээг дуусгавар болгон зээлийг компанийн энгийн хувьцаанд хөрвүүлэхээр шийдвэрлэсэн.

Зээл авах тухай хувь нийлүүлэгчдийн хурлын тогтоол хавсралт 6-д

Гэрээний эх хувь болон орчуулга хавсралт 7-д

Зээлийн зарцуулалт, шилжүүлэг хийх данс баталсан баримт 8-д

Гэрээ дуусгавар болгосон баримт шийдвэр хавсралт 9-д

Өрийг хувьцаанд хөрвүүлэх тухай шийдвэр

2010 оны 08-р сарын 31-ны өдрийн хувь нийлүүлэгчдийн ээлжит бус хурлаар компанийн нэмж гаргаж буй 3,000,000 ширхэг энгийн хувьцаанаас 2010/04/30-ны ХНХ-аар батлан Firebird групп-ээс авсан богино хугацаат зээлийн үндсэн болон хүүгийн төлбөртэй тэнцэх дүнгээр хувьцаанд хөрвүүлэн зээлдүүлэгчдэд эзэмшүүлэх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн.

Нэмж үнэт цаас гаргах тухай

Монгол Улсын “Компанийн тухай” хуулийн 43, 84 дүгээр зүйл, компанийн дүрмийн 5 дугаар заалт болон 8 дугаар зүйлийн 20.3 дахь заалтыг үндэслэн “Шарын гол” ХК-н 2010/08/31-ны өдрийн хувь нийлүүлэгчдийн ээлжит бус хурлын 01 тоот тогтоолын дагуу нэмэлт хувьцаа гарган компанийн дүрмийн санг нэмэгдүүлэн, өрийг хувьцаанд хөрвүүлж байгаа болно.

Хувь нийлүүлэгчдийн хурлын тогтоол хавсралт 21, 23-д

Хувьцаа нэмж гаргах тухай 2010/08/31-ний өдрийн 01 тоох ХНХ-ын тогтоолын тухай

Компанийн Хуулийн 43.1 болон 76.1.4-д зааснаар Компанийн ТУЗ нь компанийн зарласан хувьцааны төрөл болон хэмжээнд багтаан хувьцаа гаргах бүрэн эрхтэй. Харин Компанийн Хуулийн 34.1-д зааснаар компаниас гаргах хувьцааны тоог буюу зарласан хувьцааг компанийн дүрмээр тогтооно. Тиймээс ХНХ-ын хуралд оролцсон саналын эрхтэй хувь нийлүүлэгчдийн саналын дийлэнх олонхиор дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулснаар зарласан хувьцааны тоо хэмжээг өөрчилнө.

Компанийн 2009 оны жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайланд Компанийн өөрийн хөрөнгө буюу нийт гаргасан энгийн хувьцааг 7,231,389 гэж тусгасан. Компаниас гаргаж байгаа 3,000,000 энгийн хувьцаа нь Компанийн Хуулийн 11 дүгээр бүлэгт зааснаар Компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш байх тул их хэмжээний хэлцэл болох бөгөөд мөн хуулийн 63.1.11 болон 76.1.16 дугаар зүйлүүдэд заасны дагуу компанийн ТУЗ болон ХНХ-аас уг их хэмжээний хэлцлийг баталснаар хүчин төгөлдөр болох юм.

Компанийн нийт гаргасан 7,231,289 ширхэг энгийн хувьцаанаас 6,992,076 буюу 96.7 хувийг эзэмшигч хувьцаа эзэмшигчид хуралд оролцон саналаа өгч 2010 оны 8 сарын 31-ний өдрийн хувь нийлүүлэгчийн ээлжит бус хуралд оролцсоноор тус хурал хүчин төгөлдөр болсон.

2010 оны 8 сарын 31-ний өдрийн ээлжит бус хуралд оролцсон 6,992,076 ширхэг саналын эрхтэй энгийн хувьцааг эзэмшигчдийн ирүүлсэн саналын хуудсыг тоолоход 6,991,832 ширхэг энгийн хувьцааг эзэмшигчид нь хувьцаа нэмж гаргах, зарласан хувьцааны тоог нэмэгдүүлэх тухай нэмэлт өөрчлөлтийг дүрэмд оруулах асуудлаар зөвшөөрсөн санал өгсөн.

Дээрхийг үндэслэн, нэмж хувьцаа гаргах тухай 2010 оны 8 сарын 31-ний өдрийн 01 тоот ХНХ-ын тогтоол нь Компанийн гаргасан саналын эрхтэй энгийн хувьцааны 96.7 хувийг эзэмшигчид оролцсон, хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын 99.99 хувиар батлагдсан, хуулийн хүчин төгөлдөр тогтоол мөн.

Өрийн хувьцаагаар солих тухай 2010/08/31-ний өдрийн 03 тоот ХНХ-ын тогтоолын тухай

Компанийн Хуулийн 25 дугаар зүйлд зааснаар Компани нь зээлдүүлэгчийн зөвшөөрснөөр өрийг хувьцаагаар сольж болно. Мөн хуулийн 25.3 болон 63.1.3 дугаар зүйлүүдэд зааснаар ХНХ нь ТУЗ-ын санал болгосон өрийг хувьцаагаар

солих төслийг хуралд оролцсон саналын эрхтэй хувь нийлүүлэгчдийн дийлэнх олонхийн саналаар батална.

2010 оны 8 сарын 31-ний өдрийн ээлжит бус хуралд 6,992,076 ширхэг саналын эрхтэй энгийн хувьцааг эзэмшигчид оролцсон. Firebird нь Компанийн 3,935,892 ширхэг саналын эрхтэй энгийн хувьцааг эзэмшдэг тул түүнээс Компанид олгосон зээлийг хувьцаанд хөрвүүлэх асуудлаар сонирхлын зөрчилтэй тул уг асуудлаар санал өгөөгүй болно. Хуралд оролцсон бусад хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн саналын хуудсыг тоолоход 3,055,940 ширхэг энгийн хувьцааг эзэмшигчид нь өрийг хувьцаагаар солих тухай асуудлаар зөвшөөрсөн санал өгсөн.

Дээрхийг үндэслэн, өрийг хувьцаагаар солих тухай 2010 оны 8 сарын 31-ний өдрийн 03 тоот ХНХ-ын тогтоол нь Компанийн гаргасан саналын эрхтэй энгийн хувьцааны 96.7 хувийг эзэмшигч хувь нийлүүлэгчид оролцсон, хуралд оролцсон саналын эрхтэй хараат бус хувь нийлүүлэгчдийн саналын 99.99 хувиар батлагдсан, хуулийн хүчин төгөлдөр тогтоол мөн.

*Өрийг хувьцаанд хөрвүүлэх асуудлыг хэлэлцсэн хувь нийлүүлэгчдийн хурал зарласан ТУЗ-ийн тогтоол хавсралт 19-д
Хурлын зар хүргэсэн баримт хавсралт 20-д
Өрийг хувьцаанд хөрвүүлэх тухай хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэр хавсралт 22, 24, 25-д*

2.6.3 ЗЭЭЛИЙН ЗАРЦУУЛАЛТ

Зээлийн зарцуулалт

Огноо	Мөнгө шилжүүлэгч	Хүлээн авагч	Дүн	Тайлбар
10.04.30	Firebird Global Master Fund II	Triton Coal	427 539,24	Нийт 1 030 000 долларын задарга
10.04.30	Firebird Global Master Fund	Triton Coal	248 068,98	12р хүснэгтэд
10.04.30	Firebird Mongolia Fund	Triton Coal	354 391,78	
10.04.30	Firebird Global Master Fund II	Ellehcør Driling	41 508,66	Мөнгө хүлээн авсан талаарх тулган
10.04.30	Firebird Global Master Fund	Ellehcør Driling	24 084,37	баталгаажуулалт
10.04.30	Firebird Mongolia Fund	Ellehcør Driling	34 406,97	хавсралт 14 д
10.05.06	Firebird Global Master Fund II	Lynch&Mahoney	4 150,87	Мөнгө хүлээн авсан талаарх тулган
10.05.06	Firebird Global Master Fund	Lynch&Mahoney	2 408,43	баталгаажуулалт
10.05.06	Firebird Mongolia Fund	Lynch&Mahoney	3 440,70	хавсралт 16 д
10.05.24	Firebird Global Master Fund II	Sharyn gol	628 441,17	Мөнгө орж ирсэн, зарцуулсан дансны хуулга хавсралт 17 д
10.05.24	Firebird Global Master Fund	Sharyn gol	364 637,33	
10.05.24	Firebird Mongolia Fund	Sharyn gol	520 921,50	
10.06.01	Firebird Global Master Fund II	Ernst&Young	27 395,72	Мөнгө хүлээн авсан талаарх тулган
10.06.01	Firebird Global Master Fund	Ernst&Young	15 895,68	баталгаажуулалт
10.06.01	Firebird Mongolia Fund	Ernst&Young	22 708,60	хавсралт 15 д

10.06.27	Firebird Mongolia Fund	Sharyn gol	1 150 000,00	Мөнгө орж ирсэн, зарцуулсан дансны хуулга хавсралт 17
НИЙТ ДҮН			3 870 000,00	

Хүснэгт 11 Зээлийн зарцуулалт

Зээлийн төлбөр шилжүүлснийг батлах Firebird Global Master Fund, Firebird Global Master Fund II, Firebird Mongolia Fund-ийн дансны хуулга хавсралт 10-д

Triton Coal-ийн данснаас зарцуулсан мөнгөний зарцуулалтын задаргаа

Мөнгө шилжүүлэгч	Зарцуулалт/Хүлээн авагч	Дүн
Triton Coal	Triton Coal Management fee	120 000,00
Triton Coal	Ellehcør Drilling	264 744,72
Triton Coal	Micromine	67 095,00
Triton Coal	Allegro Recruitment	14 909,66
Triton Coal	Geologists fee	67 261,35
Triton Coal	Monkarotaj	26 444,00
Triton Coal	Salient Group	31 914,23
Triton Coal	Cover items	61 357,66
Triton Coal	Sharyn gol	376 273,38
		1 030 000,00

Хүснэгт 12 Triton Coal-ийн данснаас зарцуулсан мөнгөний зарцуулалт

*Triton Coal-тай хийсэн тулган баталгаажуулалт хавсралт 12-д
Triton Coal ХХК-ийн данснаас зарцуулсан мөнгөний тулган баталгаажуулалт
хавсралт 13-д
Дансны эцсийн үлдээгдлийн тулган баталгаажуулалт хавсралт 18-д*

Зарцуулалтын задаргаа


Нийт зарцуулалт	100%
Өрмийн ажилтай холбогдох төлбөр	98%
Аудитын төлбөр	1,7%
Хуулийн компанийн төлбөр	0,3%

Хүснэгт 13 Зарцуулалтын задаргаа

*Өрмийн ажилд зарцуулсан төлбөрийн жагсаалт хавсралт 11-д
JORC өрмийн ажлын явцын тайлан хавсралт 26-д*


Өрмийн ажил, ажлын гүйцэтгэл

Шарын гол ХК нь 2010 оны 5 сард олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн JORC стандартаар нөөц тогтоох зорилгоор өөрийн эзэмшил талбайд 13,000 уртааш метр даймонд өрмийн ажлыг эхлүүлэх гэрээтэй ажилласан.



Зураг 5 Шарын голын талбайн дэлгэмэл зураг

Зураг 4-т Шарын голын талбайн дэлгэмэл зургийг харуулсан ба тус зурагт уурхайн лицензийн талбайг **ягаан хүрээ**гээр тодруулсан.



Зураг 6 Лицензийн талбайд өрөмдлөг хийсэн кооногийн тэмдгэлгээ

Уурхайн лицензийн талбайд хамаарах 2 хэсэгт өрөмдлөг хийсэн.

1. Одоо олборлолт явуулж буй уурхайн талбайд. Зураг 5-д тус талбайд хийсэн өрөмдлөгийн цооногийн тэмдгэлгээг **улаан** цэгээр тэмдэглэсэн. Энэ хэсэгт нийт 6,655.4 метр корийн өрөмдлөг хийж 28 цооног гарган 755 анхдагч дээжийг лабораторид хүлээлгэн өгсөн.
2. Шаазгайтын ордын хэсэгт. Зураг 5-д тус талбайд хийсэн өрөмдлөгийн цооногийн тэмдэглэгээ **цэнхэр** цэгээр тэмдэглэсэн. Энэ хэсэгт нийт 11,044.5 метр корийн өрөмдлөг хийж 75 цооног гаргасан нийт 1836 дээжийг лабораторид хүлээлгэн өгсөн.

*Өрөмдлөг хийсэн цооногийн мэдээлэл хавсралт 27-д
Лабораторид хүлээлгэн өгсөн дээжийн мэдээлэл хавсралт 28-д
Байр зүйн зураглал, геофизикийн судалгаа хийсэн компаниудаас гаргасан
цооногийн координатуудын мэдээлэл хавсралт 29-д*

2010/01/01-р ажлын явц дараах байдлаар үргэлжилж байна.

- Өрмийн ажил гүйцэтгэж буй Ellehcor Drilling ХХК нь 2010 оны 5-10-р сард уурхайн лицензийн талбайд нийт 17,699.90 метр корийн өрөмдлөг хийж гүйцэтгэн 103 цооног гаргасан.
- Монкаротаж ба Жиокад компаниуд нь байр зүйн зураглал, геофизикийн судалгаа, цооногийн гүний хэмжээ, бодит өрмийн цооногийн координат, өрмийн өгөгдөл гэх зэрэг ажлуудыг тус бүр бие даан хийж гүйцэтгэн мэдээллийг нөөцийн тайлан бэлтгэгч Майкромайн компанид хүлээлгэн өгсөн.
- Stewarts Lab нь 2591 анхдагч дээжийг хүлээн авч дээжийн чийглэг, дэгдэмхий бодис, үнслэг, ууршимхай байдал, илчлэг, нийт хүхэр зэрэг чанарын үзүүлэлтүүдэд шинжилгээ хийж гүйцэтгэн мэдээллийг нөөцийн тайлан бэлтгэгч Майкромайн компанид хүлээлгэн өгсөн.
- Олон улсад нэр хүнд бүхий Майкромайн компани нь ЖОРК стандартын дагуу чанарын өндөр түвшинд хүрсэн нөөцийн тайлан бэлдэхээр ажиллаж байна. Одоогийн байдлаар төлөвлөж байсан бүх өрөмдлөгийг хийж гүйцэтгэсэн байгаа. Майкромайн компани нь бүх мэдээллийн санг бүрдүүлэн, мэдээллийг 3D загварчлалд оруулан тайлан бэлдэж байна. Нөөцийн тайлан 2010 оны 1-2 сард багтаан дуусгавар болгох төлөвлөгөөтэй байна.

Хайгуул хийсэн талбайн геологийн тогтоц ажил гүйцэтгэгчдын урьдчилсан тооцоолж байснаас хэцүү ээдрээтэй, ажлын гүйцэтгэлийн явцад нөөц таамаглаж байснаас илүү тогтоогдох урьдчилсан таамаглал гарч, тухайн таамаглалыг батлах мэдээллийг бүрэн гаргах нэмэлт өрөм тавих шаардлагатай болсон зэрэг шалтгаануудаас тайлангийн хугацаа хойшлогдоод байгаа.

2.6.4 ҮНЭ, ХУВЬЦААНЫ ТОО

Үнэ

Компанийн тухай хуулийн 25-р зүйлд заасан Өрийг хувьцаагаар солих тухай заалтыг үндэслэн “Шарын гол” ХК болон Зээлдүүлэгчдийн хооронд байгуулсан санхүүгийн хөрвөх гэрээний дагуу компанид үүссэн 3,870,000 доллартай тэнцэх 5`337`957`180 төгрөгийн үндсэн өр, зээлийн гэрээний дагуу үүссэн 118`091`941.98 төгрөгийн хүүгийн төлбөрийн нийт дүн болох 5`456`049`121.98 төгрөгийн өрийг хувьцаагаар солихдоо 2010/04/30-ны өдөр байгуулсан Хөрвөх санхүүжилтын гэрээний 15-р зүйлийн 3-т зааснаар “Өрийн нийт дүнтэй тэнцэх хэмжээний хувьцааг Зээлдэгч талаас гаргуулж, Монголын хөрөнгийн биржийн 52 долоо хоногийн жигнэсэн дундаж ханшаар тооцно” гэж заасныг баримталсан.

Үнэ тогтоосон шийдвэр:

2010 оны 07-р сарын 20-ны өдөр хуралдсан ТУЗ-ийн хурлаар өрийг хувьцаанд хөрвүүлэх нэгж хувьцааны үнийг гэрээг дуусгавар болгосон өрдөөс өмнөх сүүлийн 52 долоо хоногийн жигнэсэн дундаж ханшаар бодож тооцохоор шийдвэрлэсэн.

2010 оны 08-р сарын 31-ний Хувьцаа эзэмшигчдийн хурлаар өрийг хувьцаанд хөрвүүлэх нэгж хувьцааны үнийг 2010/07/20-ны өдрөөс өмнөх сүүлийн 52 долоо хоногийн жигнэсэн дундаж ханшаар тооцон **4221** төгрөгөөр тогтоосон.

Үнэ тогтоосон тухай шийдвэр хавсралт 22, 25-д

Зах зээлийн үнийн мэдээлэл




График 8 Хувьцааны зах зээлийн үнийн мэдээлэл

Хөрвөх үнэ нь 4.30-ний Хөрвөх зээлийн гэрээ батлагдсан болон гэрээг дуусгавар болгосон 7.20-ний өдрийн зах зээлийн ханшаас даруй 11%-аар өндөр байна.

Монголын хөрөнгийн биржийн үнийн тодорхойлолт хавсралт 5-д

Хувьцааны тоо

1	Төсөл баталсан огноо	2010/07/20
2	Компанид үүссэн өрийн дүн /USD/	3`870`000.00
3	Компанид үүссэн өрийн дүн /MNT/	5`337`957`180.00
4	Хүүгийн төлбөрийн дүн /MNT/	118`091`941.98
5	Хувьцаагаар солигдох өрийн дүн	5`456`049`121.98
6	Ханш /MNT/	4221.00
7	Хувьцааны ширхэг	1`292`596.00
8	Зөрүү дүн /MNT/	1405.98

Хүснэгт 14 Хувьцааны тоо

2.6.5 ХЭРЭГЖҮҮЛЭХ НӨХЦӨЛ

Төсөл хэрэгжих үндэслэл

Компанийн тухай хуулийн 25 болон 63-р зүйлийн дагуу компанийн эрх барих дээд байгууллага болох хувь нийлүүлэгчдийн хурлын тус асуудлаарх саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхийн саналаар энэхүү төсөл нь хэрэгжих бүрэн үндэслэлтэй болсон.

Зээлдүүлэгчдийн хувьцааны бүртгэлд орох өөрчлөлт

№	Хувьцаа эзэмшигч	Эзэмшиж байгаа ширхэг	Хөрвөх хувьцааны тоо	Нийт эзэмших ширхэг	Хувь
1	Firebird Global Master Fund	2`401`572	379`906	2`781`478	32,63%
2	Firebird Global Master Fund II	911`155	220`431	1`131`586	13,28%
3	Firebird Mongolia Fund	586`089	692`259	1`278`348	15,00%
4	НИЙТ	3`898`816	1`292`596	5`191`412	60,90%

Хүснэгт 15 Зээлдүүлэгчдийн хувьцааны бүртгэлд орох өөрчлөлт

2.6.6. ӨРИЙГ ХУВЬЦААГААР СОЛИХ ЖУРАМ

1. Компани нь 2010/07/20-ны Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурал, 2010/08/31-ны Хувь нийлүүлэгчдийн ээлжит бус хурлын шийдвэрээр нэмж хувьцаа гарган компанийн дүрмийн санг 41,5%-иар нэмэгдүүлэн нийт 10`231`389 ширхэг хувьцаатай байхаар шийдвэрлэсэн.
2. Компанийн нэмж гаргасан 3 сая ширхэг энгийн хувьцааны 43.09%-тай тэнцэх 1,292,596 ширхэг хувьцааг нэг бүрийг нь, 2010/07/20-ны өдрөөр тасалбар болгосон хувьцааны сүүлийн 52 долоо хоногийн дундаж ханш болох 4221 төгрөгөөр тооцон Firebird Group-ийн өрийг хувьцаагаар сольж Зээлдүүлэгчдэд эзэмшүүлнэ.
3. Компанийн тухай хуулийн 54-р зүйлд заасны дагуу хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцэн баталсан “Нэмэлт санхүүжилт татах”, “Өрийг хувьцаагаар солих” асуудлаар эсрэг саналтай байсан буюу санал хураалтад оролцоогүй хувьцаа эзэмшигч нь компани нэмэлт санхүүжилт татаж буй талаарх мэдээлэл олон нийтийн мэдээллийн хэрэгслээр хүргэгдсэнээс хойш 14 хоногийн дотор өөрийн эзэмшиж буй хувьцааг зах зээлийн ханшаар компанид эргүүлэн худалдахыг шаардах эрхтэй.
4. Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн өрийг хувьцаагаар солих төсөл боловсруулан хувь нийлүүлэгчдийн хуралд оруулж, уг асуудлаар саналын эрхтэй хуралд оролцогчдын дийлэнх олонхийн саналаар шийдвэрлүүлсэн.

2.6.7 ХОЛБОГДОХ БИЧИГ БАРИМТ

1. Зээл авах тухай 2010/04/30-ны хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэр
2. Зээлийн гэрээ, гэрээний орчуулга
3. Зээлийн зарцуулалт, шилжүүлэг хийх данс баталсан баримт
4. Зээлийн гэрээг дуусгавар болгосон баримт
5. Зээлийн төлбөр шилжүүлсний батлах Firebird Global Master Fund, Firebird Global Master Fund II, Firebird Mongolia Fund -ийн дансны хуулга
6. Мөнгө хүлээн авсны батлаж буй Triton Coal ХХК-тай хийсэн тулган баталгаажуулалт
7. Triton Coal ХХК-ийн данснаас зарцуулсан мөнгөний тулган баталгаажуулалт
8. Ellehcor Drilling ХХК мөнгө хүлээн авсан тухай тулган баталгаажуулалт
9. Ernst&Young ХХК мөнгө хүлээн авсан тухай тулган баталгаажуулалт
10. Lynch&Mahoney мөнгө хүлээн авсан тухай тулган баталгаажуулалт
11. HSBC банкинд байрших "Шарын гол" ХК-ийн дансанд мөнгө байршсан дансны хуулга
12. Мөнгө байршсан дансны эцсийн үлдэгдлийг баталсан банкны тулган баталгаажуулалт
13. Нэмж хувьцаа гарган өрийг хувьцаанд хөрвүүлэх тухай 2010/08/31-ний хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэр, тогтоол
14. Хөрвөх хувьцааны үнэ тогтоосон тухай ХНХ-ийн шийдвэр

15. Монголын хөрөнгийн биржээс гаргуулсан хувьцааны үнийн судалгаа
16. 2010 оны хагас жилийн болон 3-р улирлын Аудитлагдсан тайлан

2.6 ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДАД УЧИРЧ БОЛОХ ЭРСДЛИЙН ШИНЖИЛГЭЭ

2.7.1 Макро орчны шинжилгээ

1. Үнэт цаас гаргагчийн салбарын эрсдэл

Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Нээлттэй нийгэм форум, бусад судалгааны газруудын дүгнэлтээр уул уурхай, ашигт малтмалын салбар нь монголын тэргүүлэгч салбар төдийгүй цаашид хөгжих өргөн боломж нээлттэй байгааг дурджээ. Энэхүү салбарт тулгамдаж буй асуудлыг гадаад, дотоодын байгууллагууд дуу нэгтэйгээр хөрөнгө оруулалт татах болон төрийн бодлого, хууль эрхзүйн тогтворгүй байдал хэмээжээ. Бидний санаж байгаагаар гэнэтийн ашгийн татвар, тогтвортой байдлын гэрээнүүд, зэрэг гэнэтийн өөрчлөлт, шийдвэрүүд олон байсан. Улс орны хөгжлийн тулгуур салбар гэдэг утгаараа салбарын үйл ажиллагаа, зохицуулалтад төр заавал оролцох шаардлагатай болдог ч нөгөө талаас салбарын хөгжил төрийн үйл, ажиллагаатай хэт хараат байгаа нь олон эрсдлийг салбарт авчирч байна.

а. Өрсөлдөөний ердийн бус нөхцөл байдалтай холбогдсон эрсдэл

Төрийн оролцоо гэдэг утгаараа зах зээлийн бус аргаар өрсөлдөх хэлбэр олон тохиолддог. Ерөнхийдөө бол улс төрийн томоохон хүчнүүд, хөрөнгө ихтэй компаниуд зэрэг хүчтэй оролцогчид энэ салбарт ажилдаг. Бусад ижил төрлийн компаниудтай харьцуулахад:

Газар зүйн байршлаас шалтгаалаад хэрэглэгчдээ алдах, бүтээгдэхүүний борлуулалтын зардал өндөр байгаа нь ашгийг бууруулах гол эрсдэл болж байна.

- b. Тодорхой хязгаарлагдмал хүрээний эсхүл цөөн тооны бэлтгэн нийлүүлэгч, үйлчлүүлэгч, худалдан авагчаас хамааралтай байдлын эрсдэл
 - i. Борлуулсан нүүрсний 80%-ийг Дархан, Эрдэнэтийн ДЦС-дад өгч байгаа өнөө үед төрөөс тогтоосон үнийг дагахаас өөр аргагүй байдаг.
 - ii. Бүтээгдэхүүний чанар уурхайн үйл ажиллагааны шууд хамаардаггүй тул чанаргүй бүтээгдэхүүн нийлүүлэгдэх боломж өндөр байдаг.
 - iii. Цөөн тооны худалдан авагчтай байгаа нь бүтээгдэхүүний орох мөнгөн урсгал тогтвортой байх нь цөөн тооны хэрэглэгчдээс шууд хамаарах болно.
 - iv. Борлуулалтыг зээлээр хийсэн тохиолдолд дээрхийн адил эргэн төлөгдөх магадлал олон хэрэглэгчдээс муу байдаг.

2. Хүрээлэн байгаа орчны болон эрүүл ахуйн эрсдэл

Үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар байгаль орчинд үзүүлж байгаа сөрөг нөлөөллүүдээс хамгийн их нь утаа тоос, усны бохирдол, хөрсний эвдрэл, шимт хөрс, малын бэлчээр олзворлолтонд болон овоолгод дарагдаж устгагдсан байдал юм. Үүнээс:

- v. Ашиглалт эхэлсэн 1965 оноос хойш өссөн дүнгээр 326.5 га газар олзворлолтонд өртсөн, 650.1 га газрын гадарга төмөр замын болон авто бульдозерын овоолгод дарагдаж үржил шимт хөрс, малын бэлчээр устгагдсан ба овоолгын шорооны даралтын нөлөөгөөр голын болог гүний усны урсац хэмжээ өөрчлөгдөж намаг үүсэх, хөрсний гадаргын атриажилт үүсэх зэрэг сөрөг нөлөөллүүд үүссэн.
- vi. Агаар орчны бохирдол нь нүүрсний давхрагын чулуулаг, нүүрсний өөрийн шаталтын голомтоос үүссэн галын утаа, тэсэлгээний тоос болон технологийн зориулалттай автомашинуудын түлшний шаталтын хорт утаа зэргээс үүсч, сумын оршин суугчдын эрүүл мэндэд тодорхой хэмжээгээр муугаар нөлөөлдөг.
- vii. Уурхайн технологийн хэрэгцээнд ашигласан усыг “Дулаан Шарын гол” ХК-ийн бохирын шугаманд нийлүүлэн Шарын гол руу шууд урсгадаг нь голын усны найрлагыг өөрчилж, хүнд металлээр бохирдуулан гадаргын усанд сөргөөр нөлөөлдөг. Мөн уурхайгаас шүүрүүлэн зайлуулж буй усыг тунгаагуураар дамжуулан голын усанд нийлүүлдэг ба Шарын гол руу нийлүүлж буй эдгээр усны үзүүлэлтүүд нь хатуу, бохирдолтой ус байна.

Үйлдвэрлэлийн ажлын байрны сөрөг хүчин зүйлүүд нь ажиллагсадын эрүүл ахуйд муугаар нөлөөлдөг. Үүнд:

- viii. Ажлын байрны тоосжилт, хүйтэн температур, угаарын хий зэрэг сөрөг хүчин зүйлийн нөлөөнд биеийн хүнд хөдөлмөр эрхэлдэг үндсэн хэсгийн ажиллагсад гол төлөв уушигны тоосжилт, нурууны үений үрэвсэл, бөөрний үрэвсэл зэрэг мэргэжлээс шалтгаалах өвчнөөр өвчилдөг.
- ix. Автын засварчин, жолооч, бохирын слесарь зэрэг тос тосолгооны материалтай харьцан ажилладаг, химийн сөрөг хүчин зүйлийн нөлөөнд өртөж ажилладаг ажиллагсадын дунд арьс харшлын өвчин гарах тохиолдол олон байдаг.
- x. Ажиллагсадын анхаарал болгоомжгүй, ажилдаа хэт дассан байдал машин тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал алдагдсан, уул технологийн хүндрэлтэй байдал зэргээс шалтгаалан ажиллагсад үйлдвэрлэлийн осолд өртөж эрүүл мэндээрээ хохирох байдал цөөн бус гардаг. Жнь. 2006 онд 6, 2007 онд 3, 2008 онд 5 осол тус тус гарсан байна.

- xi. Гүний малталтанд илэрсэн угаарийн хий, метаны үйлчлэлд өртсөнөөс ажиллагсад /Ус шүүрүүлэх хэсгийн аврагч, малтагч/ бүлгээрээ хурц хордлогод өртсөн тохиолдол гарсан.
 - xii. Уурхайн үйл ажиллагааны нөлөөгөөр ургамал амьтны аймагт өөрчлөлт орж, уулын ажлын өрнөлтөнд болон овоолгод дарагдсан газрын ургамал устаж, газрын гадаргуу дээр амьдрагч шавьж, үет хөлтөн үгүй болж эдгээрээр хооллогч мэрэгчид, сээр нуруугүйтэн, мэрэгчдээр хооллогч махчин амьтад бас тэжээлгүй болж нүүдэллэн дайжсан байна.
- 3. Хяналт зохицуулалт, эдийн засаг, улс төрийн эрсдэл**
- a. Валютын ханшны тогтворгүй байдал нь санхүүгийн тогтвортой байдалд шууд нөлөөлж байна. Үүнээс үүдэн санхүүгийн төлөвлөгөө, төсөвт гэнтийн алдагдал хүлээх эрсдэл өндөр байдаг.
 - b. Энэхүү салбарын нийтлэг сул тал нь эцсийн хэрэглэгчдээс үүдэлтэй өрийн сүлжээ үүсч, үйл ажиллагаа доголдох нь их байдаг.
 - c. Засгийн газраас манай үндсэн бүтээгдэхүүн болох нүүрсний үнийг хязгаарлаж байдаг.
 - d. Сэлбэг, шатах тослох материалын үнийн хараат байдал нь бүтээгдэхүүний өртөгт шууд нөлөөлж алдагдал хүлээхэд хүргэж байна.
 - e. Гадаад эдийн засаг, макро орчноос үүдэлтэй өөрчлөлтүүдийн үед татвар тогтолцоо их дарамт болдог.
- 4. Үнэт цаас гаргагчийн бизнестэй холбоотой эрсдлийн талаарх дүгнэлт**
- a. Үнэт цаас гаргагчийн бизнесийн салбар нь улсын эдийн засгийн өсөлтөд голлох нөлөө үзүүлдэг ба төр болон дотоод, гадаадын байгууллагуудын бүх дэмжлэгийг авах боломжтой.
 - b. Энэ бизнес нь олон жилийн туршлага, зах зээлийн эрэлттэй тул ерөнхийдөө хөгжиж буй бизнес юм.
 - c. Бизнесийн хамгийн том сул тал нь төрийн бодлогоос бүтээгдэхүүний үнэ шууд хамаардаг тул зах зээлийн зарчмаар ажиллах боломж бага байдаг явдал юм.
 - d. Нөгөө талаас төрөөс шууд хамааралтай гэдэг утгаараа уг бизнест улс төрийн сонирхол давамгайлж байдаг нь эрсдэл дагуулсаар байна.

2.7.2 Микро орчны шинжилгээ

1. Санхүүгийн эрсдэл

- a. Нүүрсний борлуулалтаас ашиг буурах
- b. Тээврийн зардал ихтэй
- c. Өвлийн улиралд нүүрсний төлбөр төлөлт сайжирч, зуны улиралд эрс муудаж цалин хөлс, түлш хороос өөр зүйлд хүрэлцэхгүй байгаагаас зуны урин цагт хийгдэх ёстой засвар үйлчилгээ, хөрс хуулалтын ажил хоцрогдож амь аргацаах байдлаар үйлдвэрлэлээ

явуулах нь санхүүгийн байдалд сөргөөр нөлөөлж улмаар үйлдвэрлэл зогсох эрсдэлтэй.

- d. Нүүрсний чанараас хамаарч олох ашиг орлого нь өөрчлөгддөг.
- e. Нүүрс олзворлолтын хэмжээг хангаж чадахуйц хөрс хуулах, техник технологийн шинэчлэл хийх эдийн засгийн чадавхигүй болсон
- f. Бэлэн мөнгөний хомсдолтой учир заримдаа ажилчидынхаа цалинг тавихтай холбогдсон асуудлууд үүсдэг.
- g. Үнэт цаас гаргагчийн төлбөрийн чадвар санхүүгийн байдалтай холбоотой эрсдэл

Үнэт цаас гаргагчийн өмнөх жилүүдийн санхүүгийн тайланд шинжилгээ хийж, таамагласны үр дүнд төлбөрийн чадвар, санхүүгийн байдлын ирэх онуудын чиг хандлага, эрсдлийн тооцож үзэв.

- a. Мөнгөн гүйлгээ, хөрвөх чадвартай холбоотой эрсдэл
 - i. Нүүрсний үнийг төрөөс тогтоодог нь өөрийн өртгөөс бага үнээр ДЦС-ууд авдаг боловч авсан нүүрснийхээ үнийг төлөлгүй удаашруулдагаас мөнгөний үнэ цэнэ ханш өөрчлөгдөж, сэлбэг материал, түлшний үнэ нэмэгдэж урьд авсан үнээс өндөр үнээр авах болж байгаа нь өөрөө мөнгийг үнэгүйдүүлж байна. Нөгөө талаас мөнгөний эргэц удааширч тэр хугацаанд өр зээл тавьж үйл ажиллагаа явуулдагаас мөнгөний бодлого өөрчлөгдөж мөнгөөр (сэлбэг материал, түлш, цалин) үйлдвэрлэл явуулж бэлэн бүтээгдэхүүн болгодог ба үүнээс мөнгө болох цикль өөрчлөгдөж мөнгө нь - ▶ зээл - ▶ сэлбэг материал, түлш, цалин - ▶ бэлэн бүтээгдэхүүн - ▶ мөнгө болж байгаа нь зээлийн хүүд мөнгөний тодорхой хэсэг нь явж байна. Нөгөө талаас үнэ ханш өөрчлөгдсөнөөс зарим үед нүүрсний үнийг доллараар хийснээс алдагдал хүлээдэг.

2. Хүний нөөц, удирдлагын эрсдэл

- a. Гүйцэтгэх удирдлагын шийдвэрээс хамааралтай байдлын эрсдэл
 - i. Мэргэжлийн түвшинд үйлдвэрлэлээ авч явахгүй бол харилцагч худалдан авагч нараа алдах улмаар борлуулалт багасч санхүүгийн байдалд нөлөөлснөөр зах зээл дэх үнэт цаасны ханш унах эрсдэлтэй
- b. Ур чадвар, дадлага туршлагатай, мэргэшсэн ажиллах хүчний хангамжтай холбогдсон эрсдэл
 - i. Ажилчидын ажлыг дүгнэх нэгдсэн тогтолцоо бүрдээгүй байгаа нь ажилчдын идэвхи, ажилдаа хандах хандлагыг бууруулах эрсдэлтэй.
 - ii. Боловсон хүчний нөөцөө бүрэн ашиглаж чаддаггүй

- iii. Ажиллах нөхцөл хүнд бөгөөд ажилчидын шаардлагыг бүрэн хангаж чаддаггүйгээс үүдэн, чадвартай боловсон хүчинг өөртөө татаж чаддаггүй.
- iv. Цалин хөлс бага учраас дадлага туршлагатай боловсон хүчнээ өөр уурхайнуудад алдах явдал их гардаг.

3. Бизнесийн эрсдэл

- a. Үйл ажиллагааны чухал ач холбогдол бүхий лицензи, тусгай зөвшөөрөл, гэрээний хугацаатай холбоотой эрсдэл
 - i. Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл нь 30 жилийн хугацаатай. Хуулиар тогтоосон жилийн төлбөрийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд хүчингүй болж цуцлагдах эрсдэлтэй. Мөн төрийн дээд байгууллагаас ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийг нэгдсэн журмаар шинэчлэх шийдвэр гаргасан тохиолдолд тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаанд өөрчлөлт орно.
 - ii. Газар эзэмшүүлэх, ус ашиглах гэрээний дагуу тухайн жилийн газар усны төлбөрийг төлөөгүй болон гэрээг дүгнэж шинэчлэн байгуулаагүй тохиолдолд торгуулийн арга хэмжээ ноогдуулах ба хүндэтгэн үзэх шалтгаангүй үед үйлдвэрлэлийн ажиллагааг зогсоох эрсдэлтэй.
- b. Үнэт цаасыг худалдан авах ирээдүйн хөрөнгө оруулагчдын шийдвэрт нөлөөлж болох бусад бүхий л чухал үйл явдал
 - i. Хөрөнгийн зах зээл болон банкны салбарын тогтвортой бус байдал эргээд хөрөнгө оруулагчдын шийдвэрт сөргөөр нөлөөлж байна.
 - ii. Шинээр гарж буй бусад компаниудын үнэт цаасны арилжаа амжилтгүй болж байгаа нь нийт хөрөнгө оруулагчдын итгэлийг алдахад хүрсэн.
 - iii. Үнэт цаас гаргагчаас шалтгаалаагүй ч ихэнхи үнэт цаасны хөрвөх чадвар муу байдаг нь мөн хөрөнгө оруулагчдыг хөрөнгийн зах зээлээс түлхэж байдаг.
 - iv. Банкны салбарт хадгаламжийн хүү өнөөг хүртэл маш өндөр (бусад орнуудтай харьцуулахад), хадгаламжийг төр батлан даасан учир хамгийн эрсдэлгүй өндөр өгөөжтэй хөрөнгө оруулалт хэвээр байсаар байна.

2.7 АНДЕРРАЙТЕР

“БиДиСЕК” ХК нь 1995 онд байгуулагдсан бөгөөд хөрөнгийн зах зээл дээр тасралтгүй 15 жил үйл ажиллагаа явуулж буй андеррайтер, брокер, дилер хөрөнгө оруулалтын зөвлөхийн компани юм. Манай компани 2006 оны 6-р сард зохион байгуулалтын хэлбэрээ өөрчлөн олон нийтэд өөрийн хувьцааг санал болгон арилжаалан хөрөнгийн зах зээл дээрээс 1 тэрбум төгрөг, 2008 онд нэмэлт хувьцаа гаргаснаар хөрөнгийн зах зээлээс нийт 3.7 тэрбум төгрөгийг хөрөнгийг татан төвлөрүүлж үйл ажиллагааныхаа цар хүрээг өргөтгөн ажиллаж байна.

Манай компани нь Андеррайтерийн үйлчилгээ үзүүлдэг ууган компаниудын нэг бөгөөд 2005 оны 6-р сарын 07-ны өдрийн 34 тоот тогтоолоор Андеррайтерийн үйлчилгээ эрхэлэх тусгай зөвшөөрөл авсан юм. Монголын Хөрөнгийн зах зээл дээр 2005-2008 онд нийт 13 компани шинээр үнэт цаас гаргах замаар хөрөнгө оруулалт татан төвлөрүүлсэн бөгөөд “БиДиСЕК” ХК нь 8 хувьцаат компанийн Андеррайтераар ажилласан.

Мөн 2004, 2005 онд “Пума групп”-ийн Пума бонд, 2005 онд “Монинжбар” ХК-ийн “Бүтээн байгуулалт бонд”, 2007 онд “Нийслэл өргөө” ХК-ийн “Нийслэл өргөө бонд”-ын ерөнхий зуучлан борлуулагч, 2004 онд “МСиЭС электроникс” ХХК-ийн “МСиЭС электроникс бонд”-ын туслан гүйцэтгэгчээр тус тус ажилласан дадлага туршлагатай.

2.8 Үнэт цаасны талаарх дэлгэрэнгүй мэдээлэлтэй танилцаж болох газар, хариуцах ажилтны нэр, холбоо барих утасны дугаар



Монголын Хөрөнгийн Биржийн гишүүн
“БиДиСЕК” ХК

www.bdsec.mn

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Залуучуудын өргөн чөлөө 27/1, “БиДиСЕК” ХК-ний байр

Үнэт цаасны талаарх дэлгэрэнгүй мэдээлэл авч болох хариуцлагатан:

- | | | |
|-------------------|---|------------------------------------|
| 1. Нэр | : | Л.Батсуурь |
| Албан тушаал | : | ТУЗ-н н/б дарга |
| Холбоо барих утас | : | 9929-3913 |
| 2. Нэр | : | Б.Лхагвадорж |
| Албан тушаал | : | БиДиСек ХК-ийн тэргүүн дэд захирал |
| Холбоо барих утас | : | 99082846 |